- Хил дамнасан малын хулгайд угшил сайтай адуу, малын хууль бус эрэлт бий болж энэ тохиолдолд илчлэгдэх эрсдэл багатай байдал;
- Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг шуурхай шалгахад унаа, шатахууны хүрэлцээ, хангамжгүйгээс хэргийг илрүүлэх, баривчлах, таслан зогсооход цаг алдах, гэмт үйлдлээ үргэлжлүүлэх, илрэх боломжийг алдагдуулах;

Цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

- Хил орчмын мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хил залгаа улс /ОХУ, БНХАУ/-ын холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн идэвх оролцоог нэмэгдүүлэх ялангуяа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх иргэдийн идэвхи санаачлагаар байгуулагдсан холбоо, зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллах;
- Мал, мах, түүхий эдийн төвлөрсөн зах, төв замын шалган нэвтрүүлэх товчоодод тавигдаж буй хяналтын үйл ажиллагааг сайжруулахдаа хяналт, шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагын хамтын ажиллагааг үр дүнтэй болгох арга хэмжээ авах. Тухайлбал, Дархан, Булган аймгийн Цагдаагийн газар хяналтын камерыг үр нөлөөтэй ашиглаж байна.
- Малаа алдсан хохирогчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төлбөрийг барагдуулах хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах, ялангуяа хохирлын хэмжээ хүрээгүйгээс эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд мал хулгайлсан хүнд Захиргааны хариуцлагын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх;

- Мал, махны гарал үүсэл, мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээг олгодог Засаг дарга, мал эмнэлгийн эмч нарт тавих хяналтыг сайжруулж, гарал үүслийн гэрчилгээг үнэт цаасны хэлбэрт тогтоосон стандартаар нэг хэв загвартай болгох;
- Мал хулгайлах гэмт хэргийг шалгах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тасаг хэсгийн үйл ажиллагааг идэвхжүүлж, алба хаагчдыг энэ чиглэлээр дагнуулан ажиллуулж, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах. Тухайлбал, хэсгийн төлөөлөгч, цагдаагаар томилогдож байгаа алба хаагчдад малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх сургалт явуулан чадавхжуулах ажлыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага зохион байгуулж болно.
- Малчид туслах малчинг зарын дагуу авч байгаагаас тэдгээр нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгааг анхаарч холбогдох засаг, захиргаа нутаг дэвсгэрийн байгууллагаас анхааруулга, сэрэмжлүүлэг зөвлөмж өгөх
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу урамшуулах асуудлыг шийдвэрлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох талаар засаг, захиргаа нутаг дэвсгэрийн төрийн байгууллага идэвхи санаачлага гаргах, туршлага судлах
- Мал хулгайлах гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг шуурхай бүрэн бүртгэх ажил болон “Алдуул малыг бүртгэх, мэдээлэх журам”-ын хэрэгжилтийн уялдаа холбоог ханган цагдаа, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаанд шинэчлэлт хийх.

§ 8.4. Танхайрах гэмт хэргийн нөхцөл байдал

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэлийн болон Улсын Дээд шүүхийн статистик мэдээнээс үзвэл танхайрах гэмт хэрэг жил бүр өсч байх бөгөөд харин 2012 онд 7.5 хувиар, 2014 онд 8.6 хувиар тус тус буурсан байна.

Танхайрах гэмт хэргийн тоон үзүүлэлтийг 2003-2014 оны байдлаар улсын хэмжээнд нэгтгэн судалгаа хийхэд хүүхэд архидан согтуурсан үедээ гэмт хэрэгт холбогдох байдал нэмэгдэх хандлагатай байна.

2003-2014 онд улсын хэмжээнд танхайрах гэмт хэрэг нийт **20331** бүртгэгдсэн нь жилд дунджаар 1694, сард 141, өдөрт 5 гэмт хэрэг үйлдэгдэж байна гэсэн статистик үзүүлэлттэй байна.

2003-2013 онд бүртгэгдсэн танхайрах гэмт хэрэг



Тухайн онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт танхайрах гэмт хэргийн эзлэх хувь:

Нийт гэмт хэрэгт эзлэх хувь



Нутаг дэвсгэрийн байдлаар нь авч үзвэл:

Сүүлийн 12 жилийн дунджаар 1694 танхайрах гэмт хэрэг бүртгэгдсэний 39.4 хувь нь орон нутагт, 60.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Аймгуудад:



Хэнтий, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт уг төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлт өндөр байна. Тус аймгуудаар дамжин өнгөрөх иргэдийн тоо өсөн нэмэгдэж байгаа, амралт, зугаалга, аяллын чиглэл дайран өнгөрдөг газар зүйн онцлог, архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүр, бар, рестораны тоогоор улсын хэмжээнд харьцангуй өндөр зэрэг шалтгаан нь эдгээр аймагт танхайрах гэмт хэрэг буурахгүй байх нөхцлийг бүрдүүлэх магадлалтай юм.

Нийслэлд:



Бусад дүүрэгтэй харьцуулахад Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт танхайрах гэмт хэрэг илүү бүртгэгдсэн үзүүлэлттэй байгаа нь орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн дийлэнх нь тус 2 дүүрэгт суурьшдаг, газар нутаг, хүн амын тоогоор нийслэлдээ тэргүүлдэгтэй холбоотой байна.

Нийслэлийн статистикийн газраас 2013 оны байдлаар гаргасан “Нийслэлийн байгууллага, аж ахуйн нэгж”-ын судалгаа мэдээнээс үзэхэд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг зоогийн газар, зочид буудлын тоогоор бусад дүүргээс их байна.



Нийт бүртгэгдсэн танхайрах гэмт хэргийн дийлэнх хувийг хүндэвтэр, хүнд ангиллын хэрэг эзэлж байх бөгөөд 81.7 хувь нь согтуугаар, 44.7 хувь нь бүлэглэн үйлдэгдсэн байна.

Танхайрах гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байдлаас үзвэл иргэд бар, ресторан зэрэг үйлчилгээний газарт эсхүл үйлчлүүлсний дараа гудамж талбайд, мөн оршин суугаа газартаа архидан согтуурч тус гэмт хэргийг үйлдэж байна.

Тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн цагийг доорх графикаар үзүүлэв.



Иргэд ажлын цаг дуусанаас хойш үйлчилгээний байгууллага бар, ресторанд үйлчлүүлж, эсвэл оршин суугаа газартаа архидан согтуурч танхайрах гэмт хэргийг үйлдэж байгаа нь тоон судалгаанаас харагдана.

Танхайрах төрлийн гэмт хэргийг үйлдэж буй иргэдийн онцлог байдлыг хэд хэдэн үзүүлэлтээр авч үзвэл:

18-35 насныхан буюу залуучууд архи, согтууруулах төрлийн ундаа хэрэглэсэн үедээ энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байна.

Нийт холбогдогчдын 2.6 хувийг эмэгтэйчүүд эзэлжээ.



Танхайрах гэмт хэрэг үйлдэгчдийн боловсролын байдлыг үзвэл бүрэн болон бүрэн бус дунд боловсролтой иргэд 66.8 хувийг эзэлж байх бөгөөд нийгмийн байдлаар нь авч үзвэл ажилгүй, ажилчин, малчин иргэд ихэвчлэн үйлдэж байгаа нь дараах графикаас харагдана. Үүний зэрэгцээ урьд ял шийтгэгдсэн иргэдийн тоо өндөр харагдаж байна.

Бүх шатны боловсролын байгууллагад сурч буй нийт суралцагчдын 51.6 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг[2] бөгөөд энэ нь боловсролгүй, ажилгүй эрэгтэйчүүдийн тоо өсөх үндэс болж байна.

Танхайрах гэмт хэрэгт өртөж буй хохирогч иргэдийн онцлог байдлыг авч үзвэл:

Энэ төрлийн гэмт хэрэгт 18-35 насны хүмүүс илүүтэй өртөж байгаа нь тоон судалгаанаас харагдаж байна. Нийт хохирогч иргэдийн 13.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.



[2]ҮСХ, Статистикийн бюллетень, 2013.12 сар

Нийгмийн байдал



Хохирогчийн нийгмийн байдлыг үзвэл ажилгүй иргэд, оюутан сурагчдын эзлэх хувь өндөр байна.

Танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудалд

Иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд цаашид дараах арга хэмжээг авах саналтай байна.

Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд Архидан согтуурахтай тэмцэх хуулийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх саналыг зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх,
2. Цагдаагийн албаны тухай хуульд баталгаажуулагдсан Мэдээлэл нэгтгэн боловсруулах үүрэг бүхий төвийг олон улсын цагдаагийн байгууллагын жишиг туршлагын дагуу судлан байгуулах, түүний хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн үе шаттайгаар нэвтрүүлэх,
3. Иргэдийн амар тайван амьдралын баталгааг бүрдүүлэх зорилгоор олон улсын жишиг туршлага болох гэмт хэрэг, зөрчлийн цахим зураглалыг нэвтрүүлэн түүнтэй уялдуулан хууль сахиулах үйл ажиллагааг зохион байгуулах,
4. Шинээр боловсруулагдаж байгаа Эрүүгийн хуулийн төсөлд одоогийн танхайрах гэмт хэргийг “нийтийн хэв журам зөрчих” гэмт хэрэг болгон өөрчилж байгаатай холбогдуулан энэхүү гэмт хэргийн шинж, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагааны онцлогыг тодорхойлж судлах,

§ 8.5. Хүнийг санаатай алах гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал

Улсын хэмжээнд хүнийг санаатай алах гэмт хэрэг 2007-2014 онд нийт **1873** бүртгэгдсэний 49.2 хувь нь орон нутагт, 50.8 хувь нь нийслэлд үйлдэгджээ.

Дээрх үзүүлэлтийг 1 жилд ногдох дунджаар нэгтгэж танилцуулбал энэ төрлийн гэмт хэрэг жилд 234, сард 19, 1.5 хоног тутам 1 бүртгэгджээ.

$$\frac{\text{Тухайн онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг}}{\text{Тухайн онд бүртгэгдсэн нийт хүн ам}} \times 100000 = \text{түвшин тогтоох үндсэн аргачлалаар}$$

тооцоолж үзвэл Монгол Улсад 100 000 хүн ам тутамд ногдох хүнийг санаатай алах гэмт хэргийн үзүүлэлт /тоо/ нь 2007 онд 11, 2008 онд 8, 2009 онд 8, 2010 онд 8, 2011 онд 9, 2012 онд 8, 2013, 2014 онд тус бүр 7 байна.

Өөрөөр хэлбэл олон жилийн дунджаар хүнийг санаатай алах гэмт хэрэг 100000 хүн ам тутамд 8 бүртгэгдэж динамик /хөдөлгөөн/-ийн хувьд өсөөгүй, буураагүй нэгэн хэвийн үзүүлэлттэй байна.

Дээрх тоон үзүүлэлтэд дүгнэлт хийхэд хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл хөдөлгөөн хүнийг санаатай алах гэмт хэргийн гол хүчин зүйл гэж үзэхээргүй байна.

Учир нь нийслэл болон орон нутагт бүртгэгдсэн хүнийг санаатай алах гэмт хэрэг олон жилийн дунджаар 1.1 хувийн л зөрүүтэй байна.



Орон нутагт үйлдэгдсэн нийт гэмт хэргийн **1.2 хувь**, нийслэлд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн **1** хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг эзэлж байна.

Нийслэлд сүүлийн 8 жилд **99863** гэмт хэрэг бүртгэгдсэний **1** хувь нь хүнийг санаатай алах гэмт хэрэг байна.



2007-2014 онд Монгол Улсад нийт **177521** гэмт хэрэг бүртгэгдсэн ба жилд дунджаар 22190 гэмт хэрэг бүртгэгдсэний 1.1 хувь нь хүнийг санаатай алах гэмт хэрэг байна.

2007-2014 онд сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хүнийг санаатай алах гэмт хэрэг 641 бүртгэгдсэний 566 хэргийн сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдсон, үүгээр хэргийн илрүүлэлт **88.1** хувьтай байна.

2007-2014 онд хүнийг санаатай алах гэмт хэрэг нийт 1873 бүртгэгдсэний 952 нь нийслэлд, 921 нь орон нутагт байгааг нутаг дэвсгэрийн байдлаар авч үзвэл:

Жич: Төмөр зам, иргэний агаарын тээвэр, гадаад улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг дээрхи графикийн “бусад” гэсэн хэсэгт нэгтгэж оруулав.

2007-2014 онд үйлдэгдсэн хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас **1898** иргэн хохирч, үүнээс 1675 хүн нас барж, 93 хүн гэмтэж, **1887.8 тэрбум** төгрөгийн эд материалын хохирол учирсаны 70.5 хувийг нөхөн төлүүлсэн байна.

2010 онд хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 42.2 хувийг нөхөн төлүүлсэн байх бөгөөд 2011 онд 35.0, 2013 онд 14.6 хувиар тус тус өсч, 2012 онд 10.1, 2014 онд 9.0 хувиар тус тус буурсан байна.

2007-2014 онд хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлүүлэлт (сая төгрөг)



2007-2014 онд хүнийг санаатай алах гэмт хэргийн улмаас нас барсан хүн /тоогоор/



2007-2014 онд хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэгдсэн газар /тоогоор/



Гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн байдлыг үзвэл 22-06 цагийн хооронд ихээр үйлдэгдсэн байн

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг /тоогоор/



Холбогдогчдын нийгмийн байдал /2007-2014 онд тоогоор/



Гэмт хэрэг үйлдэгдсэн онцлог байдал /2007-2014 онд тоогоор/



Хүнийг санаатай алах гэмт хэргийг тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд согтуугаар үйлдэж байгаа нь тоон үзүүлэлтээс дүгнэгдэж байна.

Холбогдогчдын боловсролын байдал /2007-2014 онд тоогоор/



Гэмт хэрэгт холбогдогчдын нас /2007-2013 онд тоогоор/



Хүнийг санаатай алах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 91.1-д заасан үндсэн болон Эрүүгийн хуулийн 91.2-д заасан хүндрүүлэх бүрэлдэхүүний хувьд тус бүрд нь авч үзвэл:

А. Эрүүгийн хуулийн 91.1 дүгээр зүйлд заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алах гэмт хэрэг 2007-2014 онд улсын хэмжээнд **1108** бүртгэгдсэн нь хүнийг санаатай алах нийт гэмт хэргийн 59.2 хувийг эзэлж байна. Үүнд:

Эрүүгийн хуулийн 91.1 /тоогоор/



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд тогтоогдоогүй гэмт хэргийн илрүүлэлт /хувиар/



Дурдсан хугацаа /2007-2014/-нд бүртгэгдсэн хүнийг санаатай алах /91.1/ гэмт хэргийн илрүүлэлт дунджаар 79.0 хувьтай байна. Харин сүүлийн 6 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 90-ээс дээш хувьтай байна.

Зарим онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд тогтоогдоогүй гэмт хэргийн илрүүлэлт бага байгаа нь гэмт хэргийн тоон үзүүлэлттэй холбоотой юм. Энэ нь 2008 онд сэжигтэн тогтоогдоогүй нийт 5 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 1 нь илэрч илрүүлэлт 20 хувьтай байсан байна.

Согтуугаар үйлдэгдсэн 91.1 /хувиар/



Бүлэглэн үйлдсэн 91.1 /хувиар/



Тоон үзүүлэлтээс дүгнэн үзвэл Эрүүгийн хуулийн 91.1-д заасан гэмт хэргийн дийлэнх хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын боловсролын байдал /2007-2014 онд тоогоор/



Гэмт хэрэгт холбогдогчдын нас /2007-2014 онд тоогоор/



91.1-д заасан гэмт хэргийн улмаас нас барсан хүн /тоогоор/



Гэмт хэрэг үйлдэгдсэн газар /тоогоор 2007-2013 онд/

Б. Эрүүгийн хуулийн 91.2-д заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг санаатай алах гэмт хэрэг 2007-2014 онд улсын хэмжээнд **772** бүртгэгдсэн нь хүнийг санаатай алах гэмт хэргийн 41.2 хувийг эзэлж байна.

Эрүүгийн хуулийн 91.2 /тоогоор/



Эрүүгийн хуулийн 91.2 гэмт хэргийн илрүүлэлт /хувиар/



Дурдсан хугацаанд бүртгэгдсэн хүнийг санаатай алах /91.2/ гэмт хэргийн илрүүлэлт дунджаар 83.4 хувьтай байна.

Согтуугаар үйлдэгдсэн Эрүүгийн хуулийн 91.2 /хувиар/



Бүлэглэн үйлдсэн 91.2 /хувиар/



Тоон үзүүлэлтээс дүгнэн үзвэл Эрүүгийн хуулийн 91.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн дийлэнх хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна.

Холбогдогчдын боловсролын байдал /2007-2014 онд тоогоор/



Гэмт хэрэгт холбогдогчдын нас /2007-2014 онд тоогоор/



Гэмт хэрэг үйлдэгдсэн газар /2007-2014 онд тоогоор/

Гэмт хэргийн улмаас нас барсан хүн /тоогоор/



Хүнийг санаатай алах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, цаашид анхаарах асуудал

Манай улсад сүүлийн 8 жилийн дундаж тоон үзүүлэлтээр хүнийг санаатай алах гэмт хэрэг 100000 хүн ам тутамд 8 бүртгэгдэж динамик /хөдөлгөөн/-ийн хувьд нэгэн хэвийн үзүүлэлттэй байна.

Судалгаат хугацаанд нийт бүртгэгдсэн хүнийг санаатай алах гэмт хэрэг нийслэл болон орон нутагт нэгэн адил тоон үзүүлэлт /1.1 хувийн зөрүүтэй/-тэй байгаагаас үзвэл хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл хөдөлгөөн нь хүнийг санаатай алах гэмт хэргийн голлох хүчин зүйл бус байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.1 хувийг эзэлж байгаа хүнийг санаатай алах гэмт хэргийг ажилгүй, 18-30 насны иргэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдэж байгаад анхаарал хандуулж энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж болзошгүй нийгмийн бүлэгт чиглүүлсэн ажлыг эрчимжүүлэх /Problem Oriented Policing/ шаардлагатай.

2007-2014 онд сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хүнийг санаатай алах гэмт хэрэг 641 бүртгэгдсэний 566 хэргийн сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдсон, үүгээр хэргийн **илрүүлэлт 88.1** хувьтай байна.

Өнөөгийн байдлаар хүнийг санаатай алах дийлэнх гэмт хэрэг ахуйн хүрээнд үйлдэгдсэн байгаа нь түүний илрүүлэлтэд эерэг нөлөөлсөн байна.

Гэвч цаашдаа энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэр зохион байгуулалтын шинжтэй болох тусам цагдаагийн байгууллагаас илүү эрчимтэй /Proactive/ үйл ажиллагаа явуулахгүй бол илрүүлэлт буурч болзошгүй байна.

Иймд мөрдөн байцаалтын явцад нотлох баримтыг шинжлэн судлах төрөлжсөн лаборатори /ялангуяа ДНК/-тай болох, хэргийн газрын үзлэгт оролцож буй мэргэжилтэн, мөрдөгч нар биологийн бичил ул мөр /жишээ нь шатсан зүйлс/-ийг илрүүлэх, бэхжүүлэн ажиллах чадавхийг сайжруулах шаардлагатай.

Хүний амь нас хохирсон хэргийн газарт ажиллаж байгаа алба хаагчдад техник, хувцас хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь нэн чухал байна.

Энэ төрлийн гэмт хэргээс сэргийлэхэд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны явцад иргэдээс ирж байгаа мэдээллийн урсгалыг ашиглах, дүн шинжилгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох, цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааг эрчимжүүлэх нь чухал байна.

§ 8.6. Золгүй байдлаар болон амиа хорлож нас барсан хэрэг учралын нөхцөл байдал

Цагдаагийн байгууллагын “Гэмт хэргийн хоногийн мэдээ”-ний судалгаагаар нэг хоногт дунджаар 1-3 хүний амь нас гэмт хэргийн улмаас хохирсон дуудлага Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /102 дугаарын утас/-д ирсэн байна.

Золгүй байдлаар болон амиа хорлож амь насаа алдсан тухай мэдээлэл дээрх тооноос илүү бүртгэгдэж байгаа нь хүн ам цөөтэй манай улсын хувьд онцгой анхаарах асуудал болж байна.

Иргэд золгүй байдлаар болон амиа хорлож нас барсан хэрэг учралыг сүүлийн 12 жилийн байдлаар улсын хэмжээнд нэгтгэн үзвэл:

2003-2014 онд улсын хэмжээнд золгүй байдлаар нас барсантай холбоотой **22257** хэрэг цагдаагийн байгууллагад шалгагдсан байх ба энэ нь жилд дунджаар 1854 хүн, сард 154, өдөрт 5 хүн золгүй байдлаар нас барсан гэсэн үзүүлэлт болно.

Золгүй байдлаар нас барсан явдлыг шалгасан хэргийн тоог нутаг дэвсгэрийн байдлаар нь үзвэл:

Аймгуудад:



Дээрх үзүүлэлтээс харвал золгүй байдлаар нас барсан тоон үзүүлэлт төвийн бүсийн аймгууд буюу Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт харьцангуй өндөр байна.

Эдгээр аймгуудаар дамжин өнгөрдөг төмөр зам, авто зам, түүгээр зорчдог иргэдийн тоо харьцангуй өндөр, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтаршил, амралт, зугаалга, аяллын чиглэл дайран өнгөрдөг газар зүйн онцлог, байрлал, архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүр, бар, рестораны тоо нэмэгдэж байгаа зэрэг нь бусад аймгаас өндөр үзүүлэлттэй байхад нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй.

Нийслэлд:



Нийгэмд архидан согтуурах явдал буурахгүй байгаа ба нийтийг хамарсан арга хэмжээ, тэмдэглэлт өдрийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж тэмдэглэх болсноор архинд хордох, осгож хөлдөх, түлэгдэх, усанд живэх, санамсар, болгоомжгүйгээр өндрөөс унах зэргээр золгүй байдлаар амь насаа алдаж байна. Золгүй байдлаар нас барсан явдлыг үйлдлийн хэлбэрээр авч үзэхэд:

Архинд хордож амиа алдагсдын тоо золгүй байдлаар нас барагсдын дунд багагүй хувийг эзэлж байна. Европт хийсэн нэгэн судалгаагаар нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэрэглээг 10.0 хувиар багасгахад согтууруулах ундаанаас хамаарах эрэгтэйчүүдийн үхлийг 20.0 хувиар, золгүй осол, амиа хорлох, бусдын амь нас хохироох явдлыг 5.0 хувиар бууруулж болохыг тогтоосон байна.

Золгүй байдлаар нас барсан газар:



Амиа хорлож нас барсан талаарх судалгаа:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөлттэй холбоотойгоор хүмүүсийн сэтгэл зүй, амьдралыг үзэх үзэл бодолд тодорхой өөрчлөлт гарч байна. Эдгээр өөрчлөлтүүдтэй зэрэгцэн иргэдийн дунд бухимдал, сэтгэлийн дарамтад өртөх явдал ихэсч, үүний улмаас амиа хорлож нас барах явдал өсөх хандлагатай байна.

2003-2014 онд улсын хэмжээнд нийт 5256 хүн амиа хорлож нас барсан нь жилд дунджаар 438, сард 36.5, өдөрт 1,2 хүн нас барсан статистик үзүүлэлт болно.



Нийт амиа хорлогсдын 75.0 хувь нь эрэгтэй, 25.0 хувь нь эмэгтэй хүн байна.

2010 оны Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтэд гадны нөлөөтэй нас баралтын дотор 20-44 насны эрэгтэйчүүд зонхилох хувийг, гадны нөлөөтэй нас баралтын 15.6 хувийг амиа хорлох тохиолдол эзэлж байна гэсэн судалгаа гарсан. 2010 оны байдлаар 10000 хүн амд ноогдох амиа егүүтгэх тохиолдол эрэгтэйчүүдэд 2.72, эмэгтэйчүүдэд 0.49 хувийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүд амиа хорлох нь эмэгтэйчүүд амиа хорлох хэрэг учралаас 5.5 дахин их байсан байна[3].

Амиа хорлож нас барсан хүмүүсийг насны байдлаар нь авч үзвэл 36-аас дээш насныхан дийлэнх хувийг, насанд хүрээгүй хүүхэд багагүй хувийг эзэлж байна. Үүнд:

[3]ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС, СЭМТ. “2003-2008 онуудад Монгол Улсад амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлын тархалт” судалгааны ажлын тайлан, УБ, 2013 он

Амиа хорлож нас барсан хүмүүс насны байдлаар /2010-2014 он/



Амиа хорлож нас барсан хэрэг учралыг нутаг дэвсгэрийн байдлаар нь үзвэл:

Аймгуудад:



Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Баянхонгор аймагт амиа хорлож нас барах хэрэг учрал хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Малчин, иргэд амьжиргааны эх үүсвэрээсээ салах, амьдралын баталгаагүй болох нь амиа хорлох нэгэн шалтгаан болж байх магадлалтай юм.

Нийслэлийн хэмжээнд амиа хорлож нас барагсадын тоон үзүүлэлт дараах байдалтай байна.



Хүн амын нийслэл рүү шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд маш их идэвхжсэн. Энэ нь орон нутгаас нийслэлд ирсэн иргэдэд ажил олдохгүйгээс амьжиргааны эх үүсвэргүй болох, бичиг баримтын зөрчилтэйн улмаас нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байдалд орох, хөдөлмөр эрхэлж чадахгүй байх, амьдралын өртөг өндрөөс ядуурал орох, гэр бүлийн хүмүүсээ тэжээх чадваргүй болох байдалд орж байгаа нь архи уух, гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдох, амиа хорлох хүртэл сөрөг үр дагаварыг дагуулж байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Нийслэл хотод шилжин ирэгсдийн дийлэнхи нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт суурьшсан бөгөөд эдгээр дүүрэгт гэмт хэрэг, зөрчил, золгүй байдлаар болон амиа хорлон нас барсан хүмүүсийн тоо өндөр байгаа нь дээрх шалтгаантай холбож үзэх магадлалтай юм.

Амиа хорлох нь өөрийгөө буудах, боомилох, хутгалах байдлаар ихэвчлэн гэр, орон сууцанд үйлдэгдэж байна.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль, Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвөөс хамтран хийсэн судалгааны дүнгээс үзвэл амиа хорлох оролдлогыг дахин давтан үйлдэх тохиолдол багагүй байсан бөгөөд 10.2 хувь нь анх удаа, 0.6 хувь нь хоёр дахь удаа, 0.1 хувь нь гурав дахь удаагаа энэхүү үйлдлийг хийжээ.



Золгүй байдлаар болон амиа хорлосон тохиолдлыг бууруулахад анхаарах асуудал

Гэр бүлийн таагүй орчин, хэрүүл маргаан, дарамт, айдас, гутранги үзэл, амьдралд учрах элдэв хүндрэл, бэрхшээлийг даван туулах, тэсвэрлэх сэтгэл зүйн тэнхээгүй зэрэг ахуй, хувь хүний сэтгэл зүйн байдлаас шалтгаан амиа хорлох явдал буурахгүй байна. Амиа хорлож нас барсан хүүхдүүдийн хувьд нь гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, сургууль завсардалт, эцэг, эхийн хараа хяналт, хайр халамж, хүүхдийн сэтгэл зүйн төлөвшил, хүмүүжлээс хамааралтай байх магадлалтай юм.

Хөдөлмөрийн буюу 30-аас дээш насныхан, тэдгээрийн дотор эрэгтэй хүмүүс хөдөлмөр хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас золгүй байдлаар амиа алдаж байна. Үүний зэрэгцээ архидан согтуурсны улмаас осгож, усанд шивж, архинд хордож нас барж байгаа нь багагүй анхаарал татаж байна.

Амиа хорлолт, золгүй байдлаар нас барсан шалтгааныг тогтоох зорилгоор нутаг дэвсгэрийн хэмжээнд хийсэн судалгаа мэдээллийг нэгтгэн нэгдсэн судалгааны санг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх арга, аргачлалыг холбогдох байгууллагатай хамтран боловсруулан ажиллах шаардлагатай байна.

Золгүй байдлаар болон амиа хорлосон тохиолдол бүрийн мөрдөх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахдаа хүнийг санаатай, болгоомжгүй байдлаар алах, амиа хорлоход хүргэх гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүйг анхаарч бодит үнэнийг тогтоон эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын хэрэгжилтийг хангах нь зүйтэй.

§ 8.7. Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал

Нэг. Гэмт хэргийн ерөнхий чиг хандлага: (2003-2014 он) Сүүлийн 12 жилийн байдлаар хүчиндэх гэмт хэрэг 4064 бүртгэгдсэн ба (*жилд дунджаар 338, сард 28, хоногт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн*) нийт гэмт хэргийн **51.6 хувь** нь орон нутагт, **49.0 хувь** нь нийслэлд бүртгэгджээ.

2003-2014 онд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэрэг



Хүчиндэх гэмт хэргийг нийслэл, орон нутагт бүртгэгдсэн эзлэх хувийн жингээр нь авч үзвэл:

Тухайн хэрэгт эзлэх хувь



Дээрх график үзүүлэлтээс дүгнэхэд нийслэл, орон нутгийн хэмжээнд хүчиндэх гэмт хэрэгт эзлэх хувийн жин хоорондоо ойролцоо байх ч тухайлбал 2003, 2004, 2007, 2008, 2010, 2011, 2014 онуудад хөдөө, орон нутагт энэ төрлийн гэмт хэрэг их үйлдэгдсэн байна.

Хоёр. Сүүлийн 6 жилийн нөхцөл байдал:

2009-2014 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн Хүчиндэх **1990** гэмт хэргийн **3** хэрэг тутмын нэг нь согтуугаар, **4** хэрэг тутмын нэг нь бүлэглэн үйлдэгдсэн бөгөөд жилд дунджаар **331**, сард **28,** хоногт **1** гэмт хэрэг бүртгэгдсэн статистик үзүүлэлттэй байна.

Сүүлийн 6 жилд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн **999 буюу 50.2 хувь** нь нийслэлд, **990** буюу **49.8** хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Хүчиндэх гэмт хэрэг



2010 онд 3.0 хувь, 2011 онд 7.3 хувиар, 2013 онд 12.7 хувиар тус тус өссөн бол, 2012 онд 16.9, 2014 онд 12.8 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн илрүүлэлт



Гэмт хэргийн илрүүлэлтийн хувьд 2009-2014 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хүчиндэх гэмт хэрэг нийт 520 бүртгэгдэж, үүнээс 385 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдсон ба гэмт хэргийн илрүүлэлт **74.0 хувьтай** байна.

Нийслэл хотод бүртгэгдсэн гэмт хэргийг нутаг дэвсгэрээр нь авч үзвэл:



Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэхэд нийслэлийн алслагдмал дүүргийн гэр хороолол, хүн амын нягтаршил, ажилгүйдэл, ядуурал, архидалтын төвшин, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг хангалтгүй, цагдаагийн эргүүлийн хүн хүч, техник хэрэгслийн хүрэлцээ зэрэг нөхцөл байдлууд нөлөөлж байна.

Аймгуудад:



Үйлдэгдсэн онцлог байдал



Хүчингийн гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнх хувийг 18-39 насны эрхэлсэн тодорхой ажилгүй залуучууд эзэлж байх бөгөөд өсвөр насны хүүхдүүд буюу 14-17 насныхан ч багагүй хувийг эзэлж байна.

Хүчингийн гэмт хэрэг үйлдсэн **2** хүн тутмын нэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 2 хүн тутмын нэг нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хэрэг үйлдсэн, **3** хүн тутмын нэг нь бүлэглэн үйлдсэн, **14** хүн тутмын нэг нь урьд өмнө нь шүүхээр ял шийтгэгдсэн байжээ.



Хүчиндэх гэмт хэргийн 54.6 хувийг согтуурсан үедээ үйлдсэн байгаа нь хүүхэд, залуучуудад согтууруулах ундааг хэрэглэхгүй байх ёс суртахууны хүмүүжил төлөвшөөгүй байна.

Хэрэг үйлдэгдсэн газар



Хэрэг үйлдэгдсэн газруудыг харахад талаас илүү хувь буюу **55.8 хувь** нь гэр, орон сууцанд үйлдэгдсэн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг ахуйн хүрээнд, нуугдмал байдалд үйлдэгддэг болох нь харагдаж байна .

Хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл



Үйлдэгдсэн арга /хувиар/



Үйлдэгдсэн цаг /хувиар/



2010-2014 оны байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд тогтоогдсон, гэмт хэргийн мэдээллийн санд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлүүдээс үзэхэд зонхилох хувийг хувь хүний ёс суртахууны доголдол, бэлгийн гаж сонирхол, согтуурснаас үүдэн гэмт хэргийг үйлдсэн байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэн гарч байгаа цаг хугацааг статистик тоон үзүүлэлтээс харахад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1098 буюу **55.2 хувь** нь оройн 22 цагаас өглөөний 06 цагт голлон үйлдэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирогчдын **44.2** хувь нь бага, өсвөр насны охид түүний 95 хувь нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байна.

Хохирогчийн нас /хувиар/



Хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх зарим асуудал

Гэр бүлийн хүрээн дэх бэлгийн хүчирхийлэл нийгмийн бухимдлыг бий болгож байгаагаас гадна мэдээллийн технологийн дэвшил ялангуяа интернет хэрэглээний өнөөгийн байдал нь бага, өсвөр насны хүүхдийн сэтгэхүйд нөлөөлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд хүчиндэх гэмт хэрэгт холбогдох эсхүл хохирогч болох явдал нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хариуцлага, сургуулийн зүгээс явуулж байгаа урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүн хангалтгүй байгаатай шууд холбоотой байна. Иймд:

1. Бага болон өсвөр насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн тэдгээрт тавих хяналтыг сайжруулах (бага ангийн хүүхдийг эцэг, эхийн гараас хүлээн авах болон хүлээлгэн өгөх) талаар сургуулийн захиргаа, цагдаа, эцэг эхийн зөвлөл, багш, төрийн бус байгууллага, нийгмийн ажилтны хамтын ажиллагааг сайжруулах;
2. Орон нутагт хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд тэдний эрхийг хамгаалах, зөвлөгөө өгөх байгууллага, мэргэжилтний үйл ажиллагааг идэвхижүүлэх, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах, эрүүл мэнд, сэтгэл засал, нийгмийн бусад үйлчилгээг хүргэх төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;

(Тухайлбал, хүүхдийн хүчирхийллийн хэрэг дээр ажиллах мэргэшсэн алба хаагч, нутаг дэвсгэрийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, өмгөөлөгч, эмч)

3. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундааны аюул, хувь хүний ёс суртахууны талаарх хэрэгцээтэй мэдээлэл, сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн оюутан, сурагчдад (эрүүл мэнд, хүүхдийн, уламжлалт шашны г.м) тогтмол явуулж хэвших;
4. Хувь хүний нууц, тэр дундаа хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар ирүүлсэн мэдээлэл, гомдол гаргагчийн аюулгүй байдал, хувийн нууцлалыг хангаж ажиллах;
5. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийгэмд сөрөг нөлөө үзүүлж буй мэдээлэлд (садар самууныг хэт ил гаргасан нэвтрүүлэг, зар сурталчилгаа, кино гэх мэт) тавих хяналтыг сайжруулан, хууль зөрчсөн мэдээлэлд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон Садар самуунтай тэмцэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллах;

§ 8.8. Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал

Нэг: Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт хэргийн хандлага:

Улсын хэмжээнд сүүлийн арван хоёр жилийн хугацаанд **250639**, жилд дунджаар 20 орчим мянган гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн **3628** буюу 1.4 хувийг нь бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг эзэлж байх бөгөөд түүний **78.6 хувь** нь нийслэлд, **21.0 хувь** нь орон нутагт бүртгэгджээ.

2003-2014 онд бүртгэгдсэн булаах гэмт хэрэг



Булаах гэмт хэргийн түвшин 2007 онд хамгийн өндөр буюу өмнөх онтой харьцуулахад 285 хэрэг буюу 68.2 хувиар өсч, 2008 оноос 2011 он хүртэл буурч, 2012 онд өмнөх оноос 30.7, 2013 онд 26.8, 2014 онд 7.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт гэмт хэрэгт булаах гэмт хэргийн эзлэх хувийн жин



Улсын хэмжээнд 2003-2014 онд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг **7661** бүртгэгдсэн ба нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувийн жин 3.1 хувь байна. Дээрэмдэх гэмт хэргийн 6237 буюу **81.4 хувь** нь нийслэлд, 1503 буюу **19.5 хувь** нь орон нутагт бүртгэгджээ.

2003-2014 онд бүртгэгдсэн дээрэмдэх гэмт хэрэг



Жилд дунджаар 638 орчим, сард 53, хоногт 2 бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг бүртгэгдэж байна гэсэн статистик тоон үзүүлэлттэй байна.

Нийт гэмт хэрэгт дээрэмдэх гэмт хэргийн эзлэх хувийн жин



Дээрэмдэх гэмт хэрэг 2003, 2008, 2009 онуудад өсч, 2004-2006 онд буурч, 2007 онд 44.0 хувиар өсч, 2010-2013 он хүртэлх хугацаанд гэмт хэргийн түвшин эргээд буурч, 2014 онд дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хоёр: Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдал:

Цагдаагийн байгууллага сүүлийн 5 жилийн байдлаар (2010-2014 он) булаах, дээрэмдэх гэмт хэргийн талаарх **13074** гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэсэн ба эдгээр гомдол, мэдээллийн 11125 буюу **85.1 хувь** нь нийслэлд, 1534 буюу **11.7 хувь** нь орон нутагт 415 буюу 3.2 хувь нь бусад газарт бүртгэгдсэн байна.

Булаах, дээрэмдэх гэмт хэрэгтэй холбоотой гомдол, мэдээлэл 2012 онд 8.6 хувиар буурч, 2011 онд 8.3 хувиар, 2013 онд 23.7, 2014 онд 36.1 хувиар тус тус өссөн байна.

Булаах, дээрэмдэх гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон гэмт хэргийн гаралт



Сүүлийн 5 жилд бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэгтэй холбоотой гомдол, мэдээлэл 5380 бүртгэгдсэний 82.5 хувь нь нийслэлд, 13.6 хувь нь орон нутагт, Бусдын эд хөрөнгийн дээрэмдэх гэмт хэрэг 7694 бүртгэгдсэний 86.9 хувь нь нийслэлд, 10.4 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн нөхцөл байдал: (2010-2014 он)

Бусдын эд хөрөнгийг **булаах** гэмт хэрэг сүүлийн 5 жилд **931** бүртгэгдсэний *(жилд дунджаар 186 хэрэг)* 88.5 хувь нь нийслэлд, 17.8 хувь нь орон нутагт үйлдэгджээ.

Бусдын эд хөрөнгийг булаах хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.4 хувьтай байна. Хэргийн гаралт 2011 онд 4.2%-иар буурч, 2012 онд 30.7%-иар, 2013 онд 26.8 %-иар, 2014 онд 7.9%-иар тус тус өссөн байна.

Булаах гэмт хэргийн илрүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2011 онд 6.6 хувь, 2012 онд 10.1 хувиар, 2014 онд 4.9 хувиар тус тус буурсан, харин 2013 онд 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь тухайн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний үр дүн хангалтгүй байгаагийн нэг илрэл юм.

Нийслэлийн хэмжээнд "Бусдын эд хөрөнгийг булаах" гэмт хэргийн тоон үзүүлэлт:



Нийт бүртгэгдсэн булаах гэмт хэргийн **72.6 хувь** нь гудамж талбайд үйлдэгдсэн байна.

Хэрэг үйлдэгдсэн байдлаар авч үзвэл: Булаах гэмт хэргийн 28.4 хувийг бүлэглэн, 12.8 хувийг согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ, 16.1 хувийг хүүхэд оролцож, 4.3 хувийг эмэгтэй хүн оролцож үйлджээ.

Холбогдогсдын нийгмийн байдал



Булаах гэмт хэрэгт холбогдогчдыг насны ангиллаар авч үзвэл: 345 буюу 71.1 хувь нь 18-35 насны, 91 буюу 18.8 хувь нь 18 хүртэлх насны, 51 буюу 10.5 хувь нь 35-аас дээш насны иргэд (Үүнээс: 4.7 хувь нь эмэгтэй хүн) эзэлж байна.

2010-2014 онд Бусдын эд хөрөнгийн булаах гэмт хэргийн халдлагад нийт **745** иргэн өртөж, 26 хүн гэмтэж, 662.3 сая төгрөгийн хохирол учирсны 273.4 сая төгрөг буюу **41.3 хувийг** хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлсэн байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдлын талаар:

2010-2014 оны байдлаар **дээрэмдэх** гэмт хэрэг 2856 бүртгэгдсэний (жилд дунджаар 571 гэмт хэрэг бүртгэгдсэн) 80.0 хувь нь нийслэлд, 20.0 хувь нь орон нутагт үйлдэгджээ.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэргийн нийт хэрэгт эзлэх хувийн жин 4.3 хувьтай байна. Гэмт хэргийн гаралт жил бүр өссөн үзүүлэлттэй байх ба 2011 онд 3.1, 2012 онд 3.0, 2013 онд 12.3, 2014 онд 1.3 хувиар тус тус өссөн байна.

Дээрэмдэх гэмт хэргийн гаралт

Гэмт хэргийн илрүүлэлт

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн илрүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2011 онд 0.4 хувиар өсч, 2012 онд 9.0, 2013 онд 0.4, 2014 онд 0.9 хувиар тус тус буурсан байна. 2012 оноос хойш гэмт хэргийн илрүүлэлтийн хувь байнга буурсан үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, таслан сэргийлэх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

Нийслэлийн хэмжээнд “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэргийн тоон үзүүлэлт:

Дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг зөвхөн нийслэлийн хэмжээнд авч үзвэл Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт их бүртгэгдсэн байна. Дээрх дүүргүүдэд зөвхөн булаах, дээрэмдэх гэлтгүй бусад төрлийн гэмт хэргүүд ч их үйлдэгдэж байгаа билээ.



Гэмт хэрэг үйлдэгдсэн газар



Дээрэмдэх гэмт хэрэг гудамж талбай, олон нийтийн газарт ихээр үйлдэгдэж байгаад анхаарч зөвхөн шөнийн цагаар гэлтгүй өдрийн цагаар гудамж талбайд хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Холбогдогсдын онцлог байдал



Дээрэмдэх гэмт хэрэгт зөвхөн залуучууд холбогддог байсан бол сүүлийн үед ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд ихээр үйлдэх болсон нь гэмт хэрэг үйлдэгсэд насны хувьд залуужиж байгааг харуулж байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал



Дээрэмдэх гэмт хэрэгт холбогдогчдыг насны ангиллаар авч үзвэл: 1503 буюу 72.0 хувь нь 18-35 насны, 578 буюу 27.7 хувь нь 18 хүртэлх насны, 143 буюу 6.8 хувь нь 35-аас дээш насны иргэд эзэлж байна.

Бусдыг дээрэмдэх гэмт хэргийн 41.7 хувийг бүлэглэн, 20.4 хувийг архидан согтуурсан үедээ, 13.0 хувийг насанд хүрээгүй хүүхэд оролцож үйлдсэн байна. Сүүлийн үеийн хүүхэд, залуус амар хялбар аргаар бэлэн мөнгө, үнэтэй гар утастай

болохын тулд хэсэг бүлгээрээ нийлж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд их бага хэмжээний хохирол учруулах явдал буурахгүй байна.

2010-2014 онд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн халдлагад **2374** иргэн өртөж, 844 хүн гэмтэж, 1560.5 сая төгрөгийн хохирол учирсны 733 сая төгрөг буюу 47.0 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлсэн байна.

Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал

Булаах, дээрэмдэх гэмт хэрэгт холбогдогсод 18-30 насны, эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн дундаас доогуур боловсролтой хүмүүс архидан согтуурсан үедээ, бүлэглэж буюу давтан үйлдэхдээ цаг хугацааны хувьд харуй бүрийгээр ихэвчлэн хүний хөл хөдөлгөөн татарсан үеэр гудамж, орон сууцны байрны булан, орцонд гол төлөв биеэ хамгаалах чадваргүй хүн, хүүхэд, эмэгтэйчүүдийг зориуд сонгон үйлддэг ба өвлийн улиралд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсдөг нь статистик судалгаанаас дүгнэгдэж байна.

Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх гэмт хэргийн гаралт буурсан ч хэлбэлзэлтэй байгаа нь урьдчилан сэргийлэх ажлын үр дүн юм. Тухайлбал, камержуулалт, түүнчлэн цагдаагийн алба хаагчдын шуурхай үйл ажиллагаа иргэдийг гэмт халдлагаас хамгаалахын зэрэгцээ энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, таслан зогсоох ажилд гол нөлөөллийг үзүүлжээ.

Цаашид амь биед аюултай болон аюулгүй хүч хэрэглэсэн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн төсөлд “дээрэмдэх” гэмт хэрэг болгохоор тусгажээ.

Бусдын эд хөрөнгийг булаах, дээрэмдэх, далайлган сүрдүүлэх гэмт хэргийн хамтран оролцох хэлбэрүүдийг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлэн тогтоож, тэдгээрт үйлчилж дэмжлэг үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сүлжээг хяналтандаа авч хуулийн хариуцлага хүлээлгэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

Ерөнхий боловсролын сургууль бүрийг аюулгүй байдал, харуул хамгаалалт хариуцсан ажилтантай болгож, эдгээр ажилтнаас шаардлагатай мэдээллийн дэмжлэг авч ажлыг зохион байгуулах нь хүүхдийг энэхүү гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

--ooOoo--

§ 8.9. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал

Нэг: Хүн гэртээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид, эрүүл саруул, аюулгүй орчинд эрх тэгш амьдрах эрхтэй байдаг. Гэтэл гадны нөлөөллийн (осол гэмтэл, хордлого, гэмт хэргийн халдлага, гэр бүлийн хүчирхийлэл) улмаас эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээ авч буй шалтгаануудад гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмтэл орж байна.[4]

Энэ бол зөвхөн эмнэлэгт хандан, тусламж үйлчилгээ авч бүртгэгдсэн иргэдийн тоо юм. Гэтэл гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүрээнд "нүднээс далд", байнга давтагдах онцлог шинжтэй үйлдэгддэг бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь тэр бүр цагдаа, хууль, шүүхийн байгууллагад хандаад байдаггүй.

Тиймээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд хохирсон талаар статистик тоон мэдээ хангалттай байдаггүй. Гэр бүлийн хүчирхийлэл, дарамтнаас үүдэн хүүхэд эрүүл мэндээрээ хохирох, орон гэрээсээ дайжих, улмаар гэмт хэргийн замд хөтлөгдөн орж байна.

2010-2014 оны байдлаар улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 2782 гэмт хэрэг бүртгэгджээ. Жилд дунджаар 545, сард 45, өдөрт 1-2 хэрэг гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 75.5 хувийг хөнгөн, 14.8 хувийг хүндэвтэр, 6.5 хувийг хүнд, 3.2 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба тэдгээрийн 62.0 хувь нь нийслэл хотод, 38.0 хувь нь аймгуудад тус тус бүртгэгджээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийг Эрүүгийн хуулийн зүйл ангиар авч үзвэл:

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг 2467 буюу 90.4 хувь, танхайрах 82 буюу 3.0, хүчиндэх 74 буюу 2.7, хүнийг санаатай алах 57 буюу 2.1, бусдыг амиа хорлоход хүргэх 5 буюу 0.2, хулгайлах 2 буюу 0.07 хувийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 1237 буюу 45.3 хувь нь согтуугаар үйлдэгдэж, 177 буюу 6.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 19 буюу 0.7 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн 75.0 хувь нь санаатай, 25.0 хувь нь болгоомжгүйгээр үйлдэгдсэн байна.

2007-2014 оны байдлаар хүүхэд оролцож үйлдэгдсэн **6628** гэмт хэрэг бүртгэгджээ. Энэ нь жилд дунджаар 828, сард 69 өдөрт 2 хэрэг хүүхэд оролцож үйлдэгдэж байна.

Статистик тоон мэдээнээс үзвэл 2010 оноос хүүхэд оролцож үйлдэгдсэн гэмт хэрэг буурах хандлагатай байсан боловч 2011 онд өмнөх оноос 29.7 хувиар, 2012 онд 82.4 хүртэл хувиар өсч, 2013 онд 4.4 хувь буурч, 2014 онд 2.9 хувиар өссөн байна.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг /2007-2014 он/



Хүүхэд оролцсон гэмт хэрэг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр /2007-2014/



[4]Гэр бүл, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн өнөөгийн байдал, бууруулах арга зам сэдэвт салбар дундын зөвлөлдөх уулзалтын тайлан, Улаанбаатар хот,2008 он

Хүүхэд ихэвчлэн хулгайлах, бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдэж байгаа статистик тоо байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхэд /2011-2014 он/ (орон нутгаар)

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхэд /2011-2014 он/ (нийслэлд)

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон нийт хүүхдийн 22.3 хувийг 7 хүртэлх насны хүүхэд, 73.4 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодийн, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн гэсэн хэлбэртэй[5] байхаар заасан байдаг боловч биемахбодийн хүчирхийллээс бусад хэлбэрийг тогтоон шалгахад хүндрэлтэй байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхэд насны байдлаар /2011-2014 он/



Гэтэл гэр бүлийн хүрээнд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртөх явдал хамгийн өндөр буюу 42.6 хувьтай байх бөгөөд “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-өөс хийсэн судалгаанаас үзвэл гэр бүлийн хүрээнд хүчингийн гэмт хэрэгт өртөгсдийн 60 орчим хувь нь бага, өсвөр насны охид байх бөгөөд хохирогч жирэмсэн болох, БЗХӨ-өөр өвдөх, гэрээсээ дайжих, амь нас нь хохирсон зэрэг ноцтой үр дагаварт хүрсэн үед л илэрдэг байна.

Хүчирхийлэлд өртсөн хэлбэр /2011-2014 он/

Мөн эцэг, эхчүүд хүүхдийг алдаа гаргаж, буруу зүйл хийсний төлөө зодох зэрэг шийтгэлээр шийтгэдэг, үүний улмаас эрүүл мэнд, амь насанд аюул занал тулгараагүй л бол мэдээлэгддэггүй, бүртгэгддэггүй, далд нууц байсаар байдаг.

Хүчирхийлэл үргэлжилсэн хугацаа /2011-2014 он/



Хүчирхийлэлд өртсөн давтамж /2011-2014 он/



[5]Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2004 он, 6.1 дэх заалт

Гэр бүлийн хүчирхийлэлд хохирогч
/2011-2014 он/

Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх зарим асуудал

Цагдаагийн байгууллагад ирдэг нийт дуудлага, мэдээллийн 50 гаруй хувийг гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэлтэй холбоотой дуудлага эзлэх бөгөөд энэхүү гомдол, мэдээллийн 70 орчим хувь нь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр шийдвэрлэгддэг байна.

Энэ нь хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс гомдол, саналгүй гэсэн хүсэлттэй холбоотой бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцлийг тогтоох, түүнийг арилсан эсэхэд хяналт тавих боломжгүй байдал нь энэ төрлийн хэргийн гаралтыг бууруулахгүй, хүчирхийлэл дахин давтан үйлдэгдэх, хүчирхийлэгч ял завшиж хууль зүйн хариуцлага гарцаагүй байх зарчим хэрэгжихгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль батлагдсан ч түүнтэй хэрхэн тэмцэх арга, механизм бүрдээгүй, энэ чиглэлээр ажиллах мэргэшсэн албан хаагч (сэтгэл зүйч, эмч, гэр бүл судлаач) дутмаг, энэхүү гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгахад учирч байгаа бэрхшээл (нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээний үр дүнгээр илрэх) зэрэг нь гэр бүлийн гишүүд, тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртөх үндэс болсоор байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлж ажиллах нэгжид хүүхдийн хэрэг дээр ажиллах мэргэшсэн алба хаагч бэлтгэн ажиллуулах,
2. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх ялангуяа согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний зохистой харьцааг бий болгох, гэр бүлийн хүрээнд архидалттай тэмцэх зорилгоор төрийн болон мэргэшсэн төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авах,
3. Гэр бүлийн хүчирхийллийн явцад үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүйг боловсруулж ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхдэд шинээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоолгон нийгмийн хамгааллын арга хэмжээ авах,
4. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын байгууллага, хүүхдийн эрх ашгийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх.

--ooOoo --

§ 8.10. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал

Нэг: Монгол Улсын хэмжээнд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэг сүүлийн 7 жилийн байдлаар:

2008-2014 онд улсын хэмжээнд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой нийт **210** гэмт хэрэг үйлдэгдсэний **79.0** хувь нь нийслэлд бүртгэгджээ. /Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн **0.1** хувийг эзэлдэг байна/ Жилд дунджаар 30, сард 2.5 гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн тоо жил ирэх тусам нэмэгдсэн ба 2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулвал 63 хэргээр буюу 6.3 дахин нэмэгдэж харин 2013 онд 2.5 дахин буурсан, 2014 онд 28 хэргээр буюу 1.9 дахин нэмэгдсэн байна.

2008-2014 онд үйлдэгдсэн гэмт хэрэг /тоогоор/



Монгол Улсад сүүлийн 7 жилийн хугацаанд энэхүү гэмт хэрэгтэй холбоотой **321** холбогдогчтой **210** гэмт хэрэг бүртгэгдэж[6], цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал: Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэг 2008 онд 11 холбогдогчтой 7 хэрэг, 2009 онд 24 холбогдогчтой 8 хэрэг, 2010 онд 34 холбогдогчтой 20 хэрэг, 2011 онд 9 холбогдогчтой 12 хэрэг, 2012 онд 68 холбогдогчтой 75 хэрэг тус тус бүртгэгдсэн байна.



Харин 2013 онд 50 холбогдогчтой, 30 хэрэг, 2014 онд 125 холбогдогчтой 58 хэрэг бүртгэгджээ. /1.9% гадаад улсын иргэд холбогджээ/.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 84.4 хувийг эрэгтэй, 3.7 хувийн 16-18 насны, **73.2** хувийн 18-30 насны, 23.0 хувийг 30-дээш насны, 29.3 хувь нь дээд, 52.6 хувь нь бүрэн дунд, 14.6 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 16.8 хувь нь оюутан, сурагч, 57.6 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс үйлджээ.

Гэмт хэрэг үйлдэгсэд /2008-2014/



2008-2011 онд улсын хэмжээнд **49.8** кг каннабис, 173,2 гр гашиш, 36 ш экстози, 158 гр метафитамины төрлийн мөс, 9.6 кг геройн, 17750 ширхэг мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм, 29 ампул морфин, 32 таблетик кодейн тус тус илэрч хураагдсан байна.

[6] ЦЕГ-ын Мэдээлэл, технологийн төвийн статистикийн мэдээллээр

2012 онд 124 гр метафетамины төрлийн мөс, 92 гр гашиш, 3 кг 112 гр каннабис, 22 ш экстази, 5 кг 400 гр геройн, 29 ампул морфин, мансууруулах, 32 таблетик кодейн мансууруулах эм, 2013 онд метамфитамины төрлийн мөс 61,7 гр, гашиш 198,8 гр, каннабис 4980 гр, 32 таблетик кодейн мансууруулах эм, 2014 онд 148 гр метафитамины төрлийн мөс, 16 гр гашиш, 15 кг 100 гр каннабис, 22 ш экстази тус тус хураагдсан байна.

Цагдаагийн байгууллагад 2012 онд бүртгэгдсэн мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн 37 орчим хувийг каннабисын төрлийн бодистой холбоотой гэмт хэрэг эзэлж байсан бол энэ нь 2013 онд 60 хувьд хүрч өссөн байна. Энэ нь манай оронд их хэмжээгээр ургаж байгаа зэрлэг олсны ургамал каннабисыг устгах, хяналтанд авах зайлшгүй шаардлага үүсээд байгааг харуулж байна.

Эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан бодисын хэмжээг урд онтой харьцуулбал сэтгэцэд нөлөөт эм бодис 25 хувиар өссөн, метамфетамин мөс 50,2 хувиар буурсан, гашиш 116 хувиар өссөн, зэрлэг олсны ургамал каннабис 60 хувиар өссөн байна.



1998 оноос хойш Монгол Улсын 78 иргэн шалгагдсан



Гадаад улс оронд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл тээвэрлэх, гадаадын гэмт бүлэглэлд элсэх, олон улсын хил дамнуулан тээвэрлэлт хийх, бусдыг уг тээвэрлэлтэд зуучлах, элсүүлэх гэмт хэрэг 2009-2011 онд огцом өсч, Зүүн Өмнөд Ази, БНХАУ, Малайз, Хонг Конг зэрэг улсуудад манай улсын 26 иргэн хар тамхины тээвэрлэлт хийсэн хэргээр баригдан шалгагдсан.

Энэ төрлийн гэмт хэрэгт шалгагдсан иргэдийг улсаар нь авч үзвэл:



Дээрх нөхцөл байдалтай уялдуулан цагдаагийн байгууллагаас хил нэвтэрч байгаа иргэддээ сэрэмжлүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгт өртөхгүй байх урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, өөрийн орны иргэдийг гадаадын гэмт бүлэглэлийн захиалгаар элсүүлж, тээвэрлэлт хийлгэдэг байсан хүмүүсийг баривчлан эрүүгийн хариуцлагад татах, гэмт бүлэглэлүүдийн хууль бус ажиллагааг таслан зогсооноор 2012, 2013, 2014 онд гадаад улс оронд хар тамхины тээвэрлэлт хийсэн хэрэгт манай улсын иргэн холбогдон шалгагдаагүй байна[7].

Хоёр: 2004-2011 оны байдлаар Монгол Улсын шүүхээр мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийг шийдвэрлэсэн байдал:

Нийт 32 гэмт хэрэг шийдвэрлэж, 73 хүн ял шийтгүүлсэн (9.5 хувь нь эмэгтэй хүмүүс) байна.

Ял шийтгүүлсэн иргэдийн 75.3 хувь нь 19-30 насны, 65.7 хувь нь бүрэн дунд боловсролтой, 38.3 хувь нь эрхэлсэн тодорхой ажил, сургуульгүй, 7.5 хувь нь гадаад улсын харьяат иргэд байна.

2011-2014 оны байдлаар Монгол Улсын шүүхээр мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг эрс өссөн байна.



Гурав: Монгол Улсын хэмжээнд 2014 онд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотойгоор үйлдэгдсэн 58 гэмт хэрэг бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 28 хэргээр буюу 2 дахин өссөн. Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 0.2 хувьтай байна.

Гэмт хэргийн ангиллаар нь авч үзвэл: 30 буюу 51.7 хувийг хүндэвтэр, 27 буюу 46.5 хувийг хүнд, 1.7 хувийг он хүнд гэмт хэрэг эзэлж байна.

[7] Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын танилцуулга 2014.02 сар

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой нийт гэмт хэргийн 91.3 хувь нь нийслэлд үйлдэгджээ. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 19 хэрэг бүртгэгдсэнээс 18 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдсон ба гэмт хэргийн илрүүлэлт 94.7 хувьтай байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар /тоогоор



Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэгт 125 хүн холбогдсоны 4.8 хувь нь 16-17 насны, 36.8 хувь нь 18-24 насны, 36.0 хувь нь 25-29 насны, 13.6 хувь нь 30-34 насны, 4.0 хувь нь 35-39 насны, 1.6 хувь нь 45-49, 1.6 хувь нь 55-59 насны, 0.8 хувь нь 60-64 насны, 0.8 хувь нь 65-69 насны хүмүүс бүртгэгджээ.

Гэмт хэрэг үйлдэгсдийн нас



Нийгмийн байдлаар авч үзвэл 6.4 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 14.4 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 19.2 хувийг оюутан, 50.4 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй, 49.6 хувийг бүрэн дунд, 32.8 хувийг дээд боловсролтой, 47.2 хувь нь бүлэглэн, 52.0 хувь нь мансуурсан үедээ үйлджээ.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл анхаарах зарим асуудал

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах явдал жил ирэх тусам өссөн нь геополитик, нийгэм, эдийн засгийн байдал, хөгжил, дэд бүтэц, хяналт шалгалт, эрх зүйн орчин, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар, сэтгэхүй, төлөвшил, гадаад орны зарим иргэдийн сөрөг нөлөөллөөс шалтгаалж байна.

Түүнчлэн зарим аймгийн нутаг дэвсгэрт мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлийн гаралтай ургамлын тархац, уг бодисын хамааралтай иргэд, гадаадын иргэд, амар хялбар аргаар мөнгө олж амьдрах хүсэл эрмэлзлэл, шунал давамгайлсан, хувь хүний ухамсар, ёс суртахуун, энэ төрлийн гэмт хэрэг, түүний хор уршгийн талаарх ойлголт хангалтгүй, өсвөр насны хүүхдүүд “бухимдлаа тайлах”, ”дуурьяах“,”нөлөөнд автах” зэргээр энэ төрлийн бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож байна.

Сүүлийн үед лабораторийн аргаар боловсруулсан мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хэрэглэж байгаагаас үзэхэд уг бодисын нэр төрөл олширч, үйлчилгээ хурдан мансууруулах төрлийн бодис хэрэглэдэг, хэрэглэгчийн давхарга бий болж, донтогчдын нас залуужин хэрэглэгч, зуучлагч, тээвэрлэгч хэдийнээ бий болжээ.

Монгол Улсын хэмжээнд өсвөр үе, залуучуудын архи, тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус хэрэглээ нь хэвлэл, мэдээллийн чөлөөт байдал,

интернэтийн дэвшилтэт техник, технологи нэвтэрсэнтэй холбоотой бөгөөд үндэсний аюулгүй байдлын хэмжээнд аюул заналхийллыг хэдийнээ бий болгожээ.

Цаашид энэхүү төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хангах зорилгоор ОХУ болон БНХАУ-ын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, стратегийн баримт бичгүүдтэй уялдсан баримт бичгүүдийг боловсруулан баталж, олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох,
2. Зохион байгуулалттай, улс дамнасан гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон энэхүү гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллагын бүтэц, тогтолцоог бий болгон урьдчилан сэргийлэх, угтаж илрүүлэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, олон улсын улсын жишиг, туршлага нэвтрүүлэх
3. Улсын хэмжээнд сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх, хууль бусаар худалдах явдлыг таслан зогсоох зорилгоор эм, бэлдмэл худалдах, үйлчлэх зөвшөөрөлтэй эмийн сангийн эмийн эргэлт, худалдан авалтад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг чангатгах, эрчимжүүлэх,
4. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн бодис агуулагч ургамлын тархацын талаарх судалгааг тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын албадтай хамтран зохион байгуулж, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан ургамлын тархац, төрлийг нарийвчлан тогтоож, зураглалыг нуцын зэрэглэлтэйгээр гаргах, орон нутгийн байгаль орчны албатай хамтран жил бүр тухайн ургамлын тархацтай бүс нутгийг шинэчлэн тогтоож, байнгын устгал хийх ажлыг тогтмолжуулах,
5. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлд донтох нь хэрэглэгчийн хувьд өвчин тул донтой хүнд олон улсын жишиг, туршлагын дагуу олон талт эмчилгээ хийх бололцоо нөхцлийг бүрдүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллага үйл ажиллагаагаа чиглүүлэх,
6. Зүүн өмнөд Азийн улс орнуудын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагатай харилцаа холбоо тогтоож, мэдээ, мэдээлэл солилцохоос гадна хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
7. Монгол иргэд олноор зорчиж, сурч ажиллаж, амьдарч гэмт хэрэгт холбогдож байгаа БНХАУ-ын Бээжин болон Хонконг, Макао, Эрээн, Хөх хот, Малайзын Куала Лампур, ОХУ-ын Улаан-Үд, Москва, Унгар улсын Будапешт, Солонгос улсын Сөүл, Турк улсын Анкара зэрэг улсуудад Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яаманд гэмт хэрэгт хохирсон болон холбогдон шалгагдаж байгаа өөрийн орны иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, улс дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ижил төстэй байгууллагуудын хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн атташе томилон ажиллуулах;

--ooOoo--

§ 8.11. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал

Нэг: Монгол Улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг сүүлийн 12 жилийн байдлаар: 2003-2014 онд улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн нийт **55243** гэмт хэрэг бүртгэгдсэний **40.2 орчим** хувь нь нийслэлд бүртгэгджээ. /Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн **20.6** хувийг эзэлж байна/

Жилд дунджаар 4603 гэмт хэрэг бүртгэгдэж, сард 383, хоногт 16 гэмт хэрэг гарсан байна.

2003-2014 онд бүртгэгдсэн гэмт хэрэг /тоогоор/



	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Импортын үнийн дүн /сая.ам доллар/[8]							
Согтууруулах ундаа	21.8	11.3	19.0	25.4	33.4	32.2	26.8
Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ /сая.литр/							
Спирт	6.8	3.5	3.6	3.4	3.3	1.9	3.1
Архи дарс	15.3	17.4	20.4	25.6	26.9	24.8	24.3
Шар айраг	19.9	32.4	44.9	57.1	65.1	63.8	67.7
Нэг хүнд ногдох согтууруулах ундаа /мян.литр/							
Согтууруулах ундаа	24.6	26.0	35.4	39.5	44.4	43.1	40.3

Улсын хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэдэг аж, ахуй нэгж[9]

	Спиртийн үйлдвэр	Архины үйлдвэр	Пивоны үйлдвэр	Дарсны үйлдвэр
2007	15	74	14	10
2008	14	75	15	6
2009	12	78	13	8
2010	12	79	15	8
2011	12	71	7	7
2012	9	58	14	6
2013	2	39	17	8
2014	8	38	17	8

[8] ”Цаг үе, дэнс” сэтгүүлээс
[9] Нийгмийн хэв журам хамгаалах газрын танилцуулга /2007-2014он/

Улсын хэмжээнд согтууруулах ундааны зүйл худалддаг түүгээр үйлчилдэг байгууллага аж, ахуйн нэгж

Он	Үйлчилдэг				Худалддаг			
	Зоогийн газар	Диско	Караоке	Кафе	Хүнсний дэлгүүр		Нийт	Бөөний төв
					Орон сууцны хороолол	Гэр хороолол		
2007	614	596	331	427	2085	3457	5542	172
2008	550	569	255	344	2041	3359	5400	178
2009	569	630	274	453	1993	3811	5804	214
2010	874	879	538	585	3227	4682	7909	248
2011	1045	787	461	567	2370	4457	6827	217
2012	982	536	615	589	2304	4047	6351	185
2013	975	493	790	514	2365	4473	6838	225
2014	1013	483	825	487	2358	3930	6288	250

2007-2014 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 997250 хүн эрүүлжүүлэгдэж (**6.8** хувь нь нийслэлд, 44.6 хувь нь аймагт, 8.6 хувь нь бусад газарт) жилд дунджаар 124656, сард 10388, хоногт 346, цагт 14 хүн саатуулагдсан гэсэн статистик үзүүлэлт байна.

Эрүүлжүүлэгдсэн хүн /тоогоор/



2010-2014 оны байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах гэмт хэрэг **68.5 хувийг** эзэлж байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл /тоогоор/



ХОЁР: 2014 оны байдлаар согтуугаар үйлдэгдсэн **6686** гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 39.0 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэтэй харьцуулахад 280 буюу 4.4 хувиар өссөн байна. Сард дунджаар 557, хоногт 18 гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Гэмт хэргийг ангилалаар



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 2960 бүртгэгдсэн байх ба энэ нь согтуугаар үйлдэгдсэн нийт хэргийн 53.1 хувийг эзэлж, **86.5 хувийн** илрүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Хүчиндэх гэмт хэрэг 14 буюу 8.0 хувь, Бусдын эд хөрөнгийн булаах гэмт хэрэг 5 буюу 13.9 хувь, Танхайрах гэмт хэрэг 70 буюу 6.4 хувиар тус тус буурсан.

Гэмт хэргийн төрөл /тоогоор/

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 3 буюу 5.1 хувь, Бусдын эд хөрөнгийн хулгайлах гэмт хэрэг 17 буюу 2.3 хувь, Хүнийг санаатай алах гэмт хэрэг 9 буюу 6.4 хувь, Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 245 буюу 7.5 хувь, Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 13 буюу 7.2 хувь, Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг 10 буюу 62.5 хувь, ТХХАБАЖЗөрчих гэмт хэрэг 77 буюу 18.7 хувиар тус тус өссөн байна.

Согтуугаар үйлдэгдсэн нийт гэмт хэргийн **51.2 хувь нь нийслэлд, 48.1 хувь нь аймгуудад** 0.7 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Нийслэлийн дүүрэг /тоогоор/

Аймаг /тоогоор/



Үйлдэгдсэн гараг /тоогоор/



2014 оны байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг гараг, цагаар авч үзвэл даваа-баасан гарагуудад зонхилж, 22.00-06.00 цагийн хооронд гэмт хэргийн 47.6 хувь нь тус тус үйлдэгджээ.

Үйлдэгдсэн цаг /тоогоор/



Үйлдэгдсэн газар /тоогоор/

Нийгмийн байдал /тоогоор/

Согтуурруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдсэн иргэдийн **1.8** хувь нь хүүхэд**, 6.8** хувь нь эмэгтэй хүн байна.

2014 онд согтуурруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдсэн иргэдийн **48.1 хувь нь 18-29 насны**, 29.1 хувь нь 30-39 насны, **48.7 хувь эрхэлсэн тодорхой ажилгүй**, 46.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 5.1 хувь нь урьд нь шийтгэгдсэн хүмүүс байна.

Боловсролын байдал /тоогоор/



Гэмт хэрэгт холбогдогчдын насны ангилал /тоогоор/



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас 5848 иргэн хохирсны 31.8 хувь нь эмэгтэй, 4.2 хувь нь насанд хүрээгүй хүмүүс байх ба 322 хүн нас барж, 4224 хүн гэмтэж, 5.9 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

Хохирсон иргэдийн насны ангилал /тоогоор/



Нийгмийн байдал /тоогоор/

Монгол Улсын хэмжээнд 2014 онд нийт 681222 захиргааны зөрчил бүртгэгдсэний **9.4** хувь нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ үйлдэгдсэн байна.

Согтолтын зэрэг /хувиар/



Архи согтууруулах ундааны зүйл удаа дараа хэрэглэн зөрчил үйлдсэн 1537 иргэнд баривчлах арга хэмжээ авсан байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар **3140** зөрчил бүртгэгдсэний 2018 иргэн, 15 албан тушаалтан, 1105 аж, ахуйн нэгж байгууллагыг 385.7 сая төгрөгөөр торгож, 5 литр спирт, 2349 литр архи, 3598 литр пиво, 13 литр дарс хураажээ.

Нийт 119015 хүн саатуулагдсаны (54.6 хувь нь нийслэлийн дүүргүүдэд, 45.4 хувь нь аймгуудад), **81.5** хувь нь ажилгүй иргэд, 5.1 хувь нь эмэгтэй, 0.6 хувь нь насанд хүрээгүй хүмүүс, 0.1 хувь гадаадын иргэн, харъяалалгүй хүн бүртгэгджээ.

Эрүүлжүүлэгдсэн газар /тоогоор/

Эрүүлжүүлэгдсэн шалтгаан /хувиар/



Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах асуудалд

Монгол Улсын хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 39.0 хувь нь согтуурсны улмаас үйлдэгдсэн байх бөгөөд хүн амын хэт төвлөрөл, согтууруулах ундааны зохистой хэрэглээний соёл, төлөвшил, ёс суртахуун, гэр бүлийн орчин, байгууллага, хамт олон, найз нөхдийн харилцаа, нөлөөлөл зэргээс шалтгаалан согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх явдал буурахгүй, түүнээс улбаалан гарах сөрөг үр дагавар, хор уршиг нь жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд иргэдээс мэдээлэл ирэх механизмыг бүрдүүлэн, санд цугларсан мэдээллийг нэгтгэн боловсруулж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хэрэглэх бүтэцийг бий болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх,
2. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх олон нийтийн газруудыг байгуулах нь согтууруулах ундаагаар үйлчлэх газраас эдийн засгийн ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх тухайлбал, татварын хөнгөлөлтийн төрийн зохицуулалтыг хийх талаар холбогдох яам, агентлагт холбогдох саналыг хүргүүлэн хамтран ажиллах,
3. Цагдаагийн байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран архидан согтуурахын хор уршгаас сэрэмжлүүлсэн санамж, зөвлөмжийг иргэд, олон нийтэд хүргэж, архидалтыг багасгах, зөв зохистой хэрэглэхэд нөлөөлөхүйц арга хэмжээг оновчтой зохион байгуулах,
4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ялангуяа хууль дээдлэх, эрх зүйн соёл, ухамсарыг төлөвшүүлэхэд төрийн, төрийн бус байгууллага түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагаас нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэхэд цагдаагийн байгууллага, алба хаагч хамтран сургалт, сурталчилгааг чиглүүлэн ажиллах,

--ooOoo--

§ 8.11. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах асуудал

Улсын хэмжээнд гудамж талбай зэрэг нийтийн эзэмшлийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд 2003-2014 он буюу сүүлийн 12 жилийн хугацаанд **250639** гэмт хэрэг бүртгэгдсэний **46473** буюу **18.5** хувь нь гудамж талбайд үйлдэгдсэн байна. Гудамж талбайд жилд дунджаар **3872,** сард **322,** хоногт **10** хэрэг бүртгэгджээ.

Сүүлийн арван хоёр жилийн байдлаас үзэхэд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 2003, 2004, 2005 онуудад буурсан, 2007 онд **24.0** хувиар өссөн үзүүлэлттэй байх бөгөөд түүнээс хойшхи онуудад бүртгэгдсэн гэмт хэрэг зарим онд өсч, зарим онд буурсан үзүүлэлттэй байж байгаад 2013 онд хамгийн өндөр буюу **42.5** хувиар өссөн байна.

Нийслэлийн хэмжээнд авч үзвэл: 2003-2005 онуудад гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй, 2006 онд 18.1 хувь, 2007 онд хамгийн их буюу **32.0 хувиар** өссөн ба 2008-2011 онуудад тогтвортой, харин 2012 онд **10.0,** 2013 онд **51.3, 2014 онд 7.2 хувиар** тус тус өсчээ.

ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 01 тоот тушаалаар батлагдсан "Гэмт хэргийн бүртгэл" /ГХТБ-2100/ маягтад тусгагдсан мэдээллийг үндэслэн *гудамж талбайд* гэр хорооллын гудамж, орон сууцны хорооллын гудамж, тоглоомын талбай, ил зогсоол, цэцэрлэгт хүрээлэн, автобусны буудал, төмөр зам зэрэг газрыг судалгаанд хамруулав.

Нэг: Сүүлийн 6 жилийн байдлаар улсын хэмжээнд гудамж талбайд үйлдэгдсэн **25462** гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэрэгт 18.9 хувийг эзэлж байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 29.4 хувь нь орон нутагт, 70.5 хувь нь нийслэлд бүртгэгджээ.



Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт 2011 онд 6.2 хувиар буурсныг эс тооцвол, 2010 онд 8.3, 2012 онд 7.2, 2013 онд 42.5, 2014 онд 4.8 хувиар тус тус өссөн байна.

Сүүлийн 6 жилийн байдлаар сэжигтнээр тооцвол зохих этгээд тогтоогдоогүй 9835 гэмт хэрэг бүртгэгдэж 5974 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдож, илрүүлэлт 60.7 хувьтай байна.

Үйлдэгдсэн гэмт хэргийн халдлагад **21978** иргэн, **8** байгууллага өртөж, **20388** сая төгрөгийн хохирол учирч, түүний 45.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба 432 хүн нас барж, 11528 хүн эрүүл мэндээрээ хохирчээ.

Нийслэл хотод сүүлийн 7 жилд үйлдэгдсэн гэмт хэрэг түүний илрүүлэлтийн байдлыг хүснэгтээр үзүүлвэл:

Дүүрэг	Бүх гэмт хэрэг							
	2008	**2009**	**2010**	**2011**	**2012**	**2013**	**2014**	**Бүгд**
БГД	1868	2043	1938	2009	2372	2521	2775	15526
БЗД	2476	2147	2188	2137	2739	3742	4263	19692
СБД	1757	1708	1639	1643	2102	2416	2593	13858
СХД	1997	2232	2081	1923	2127	2778	3039	16177
ХУД	952	1123	1090	1121	1175	1236	1484	8181
ЧД	1230	1498	1360	1469	1807	2115	2392	11871
БНД	307	293	251	218	278	278	236	1861
БХД	3	23	14	11	20	31	23	125
НД	311	272	302	242	290	302	339	2058
Нийслэл	**10901**	**11339**	**10863**	**10773**	**12910**	**15419**	**17144**	**89349**
Дүүрэг	Илрүүлэлтийн хувь							
	2008	**2009**	**2010**	**2011**	**2012**	**2013**	**2014**	**Бүгд**
БГД	39.4	51.2	58	61.8	64.7	62.5	63.6	**57.3**
БЗД	23.4	52.6	53.7	57.1	39.6	51.8	48.2	**46.6**
СБД	33.1	56.6	61.2	58.3	46.0	53.6	55.2	**52.0**
СХД	30.1	40.6	41.1	57.9	58.9	60.3	58.5	**49.6**
ХУД	51.1	50.9	54.8	58.7	58.4	55.9	59.2	**55.6**
ЧД	32.4	52.7	59.8	60.0	55.1	57.8	54.8	**53.2**
БНД	50.0	53.1	59.4	61.8	67.2	63.6	71.4	**60.9**
БХД							66.7	**9.5**
НД	28.4	61.1	68.0	64.7	65.8	60.5	76.4	**60.7**
Нийслэл	**32.3**	**50.0**	**53.5**	**58.8**	**51.7**	**56.5**	**55.3**	**51.2**

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт өндөр бүртгэгдсэн байгаа нь эдгээр дүүргүүдэд оршин суугаа болон шинээр шилжин ирж байгаа иргэдийн тоо, хүн амын нягтаршил, ажилгүй иргэдийн тоо зэрэг хүчин зүйлсүүдтэй холбоотой юм.

Гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2011 онд 5.3 хувиар өссөн, 2012 онд 7.1 хувиар буурсан, 2013 онд 4.8 хувиар өссөн, 2014 онд 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийлэлийн дүүргүүдийн гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоогоор Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд мөн л бүртгэгдсэн гэмт хэргийн тоогоор бусад дүүргүүдээс илүү байгаа нь харагдаж байна. Гэмт хэрэг хамгийн ихээр гардаг газруудад гэр хорооллын гудамж, орон сууцны хорооллын гудамж, автомашины ил зогсоол хамаарч байна.

Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг дүүргээр авч үзвэл:

Дүүрэг	Гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг (2008-2014 он)							
	2008	2009	2010	2011	2012	2013	2014	Бүгд
БГД	513	426	333	336	372	691	750	3421
БЗД	437	429	559	562	606	1118	1199	4910
СХД	505	540	454	432	435	740	760	3866
СБД	365	286	422	343	424	436	503	2779
ХУД	96	132	145	148	163	297	307	1288
ЧД	278	257	475	469	515	561	628	3183
БНД	57	80	69	53	62	61	56	438
БХД		7	7	2	7	9	6	38
НД	50	48	63	36	36	52	43	328
Нийслэл	**2301**	**2205**	**2527**	**2381**	**2620**	**3965**	**4252**	**20251**

Дүүрэг	Гудамж талбайд согтуугаар үйлдэгдсэн хэрэг (2010-2014 он)					
	2010	2011	2012	2013	2014	Бүгд
БГД	187	273	280	247	216	1203
БЗД	422	413	432	314	311	1892
СХД	282	192	355	162	177	1168
СБД	305	229	368	119	130	1151
ХУД	111	101	118	63	68	461
ЧД	355	417	451	187	198	1608
БНД	5	6	120	30	29	190
БХД	112	98	9	7	5	231
НД	130	82	81	17	19	329
Нийслэл	**1909**	**1811**	**2214**	**1146**	**1153**	**8233**

Нийслэлд гудамж талбайд 2010-2014 онд 15745 гэмт хэрэг үйлдэгдсэн нь сүүлийн 5 жилд гудамж талбайд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 71.5 хувийг эзэлж байна. (2010-2014 онд гудамж талбайд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 8233 үйлдэгдсэн нь гудамж талбайд үйлдэгдсэн хэргийн 52.3 хувийг эзэлж байна.)

Гудамж талбайд үйлдэгдсэн нийт хэргийг авч үзвэл: 38,3 хувийг бусдын биед гэмтэл учруулах хэрэг, 17.6 хувийг хулгайлах гэмт хэрэг, 15.7 хувийг танхайрах, 8.7 хувийг дээрэмдэх гэмт хэргүүд эзэлж байна.

Сүүлийн 5 жилд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийг хэрэг гарсан газраар болон хэргийн өнгөөр нь авч үзвэл Гэр хорооллийн гудамжинд 9590 хэрэг үйлдэгдсэн нь нийт хэргийн 43.5 хувийг, **орон сууцны хорооллын гудамжинд** 6391 гэмт хэрэг үйлдэгдсэн нь нийт хэргийн 29.0 хувийг, **автомашины зогсоол** дээр 2030 гэмт хэрэг үйлдэгдсэн нь нийт хэргийн 9.2 хувийг, **автобусны буудал** дээр 1243 гэмт хэрэг үйлдэгдсэн нь нийт хэргийн 5.6 хувийг, **тоглоомын талбайд** 156 хэрэг үйлдэгдэж нийт хэргийн 0.7 хувийг, **цэцэрлэгт хүрээлэнд** 194 хэрэг үйлдэгсэн нь нийт хэргийн 0.9 хувийг тус тус эзлэж байна.

2010-2014 онд гудамж талбайд нийт **21978** хүн гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хохирсон иргэдийн гэмт халдлагад өртсөн байдлыг хэргийн өнгөөр авч үзвэл хүнийг санаатай алах хэрэгт 173, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг учрал 209, бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэгт 8525, хүчиндэх гэмт хэрэгт 227, хулгайлах гэмт хэрэгт 3811, булаах гэмт хэрэгт 543, дээрэмдэх гэмт хэрэгт 1951, танхайрах гэмт хэрэгт 3531, бусад гэмт хэрэгт 3008 иргэн өртөж амь нас эрүүл мэндээрээ хохирчээ.

Хоёр. 2014 оны улсын хэмжээний нөхцөл байдал: Гудамж талбайд 5622 гэмт хэрэг бүртгэгдсэн нь *(нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 20.6%)* өмнөх оны мөн үеийнхээс 258 хэргээр буюу 4.8 хувиар өссөн. Сард дунджаар 468, хоногт **16** орчим гэмт хэрэг гудамж талбайд үйлдэгдэж байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 75.6 хувь нь нийслэлд, 24.2 хувь хөдөө орон нутагт үйлдэгджээ.

2014 онд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн зөвхөн нийслэлийн хэмжээний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 287 хэргээр буюу **7.2 хувиар** өссөн байгаагаас харахад гудамж талбайд гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаагийн нэг илрэл юм.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг (тоогоор)



Сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 2932 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 1783 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдсон ба гэмт хэргийн **илрүүлэлт 60.8** хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад **3.0** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт



Хэдийгээр гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн илрүүлэлт тодорхой хувиар өссөн боловч энэ нь хангалттай тоо биш юм. Энэ нь гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдэжд байгаа тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, арга ажиллагаа дутмаг байгааг харуулж байна.

Нийслэлийн дүүргүүдийн гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал:

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг (ЭХ-ийн зүйл ангиар)





Дээрхи графикаас харахад гэр хорооллын гудамж, орон сууцны гудамжинд үйлдэгдсэн гэмт хэргийг гудамж талбайд үйлдэгдсэн нийт гэмт хэрэгт эзлэх хувь өндөр байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн *38.5 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 18.9 хувь нь хулгайлах, (үүнээс 65.0 нь хувийн өмч, 16.4 нь халаасны хулгай, 2.1 хувь нь малын хулгай, 15.8 нь тээврийн хэрэгслийн хулгай), 13.3 хувь нь танхайрах, 8.5 хувь нь дээрэмдэх* гэмт хэргүүд голчлон үйлдэгдсэн ба дээрхи төрлийн гэмт хэргүүд нь гудамж талбайд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 79.2 хувийг эзэлж байна.

Түүнчлэн залилан мэхэлж авах гэмт хэрэг 5.0 хувь, булаах гэмт хэрэг 2.7, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 1.0, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 0.5, хүчиндэх гэмт хэрэг 0.8, хүнийг санаатай алах гэмт хэрэг 0.5 хувийг тус тус эзэлж гудамж талбайд үйлдэгджээ.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэгт **5022** хүн холбогдон шалгагдсаны 11.1 хувь нь эмэгтэй, 7.3 хувь нь хүүхэд, **33.4 хувь нь 18-24 насны, 20.0 хувь нь 25-29 насны, 39.1 хувь нь 30-аас дээш насны,** 19.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 7.9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажилтай, 9.9 хувь нь оюутан, сурагч, 0.9 хувь нь тэнэмэл, 4.2 хувь нь ажилчин, малчин, 3.5 хувь нь төрийн алба хаагч, 50.5 хувь нь ажилгүй иргэд байна. Эдгээр хүмүүсийн 1645 буюу 32.7 хувь нь согтуугаар, 1126 буюу 22.4 хувь нь бүлэглэн, 205 буюу 4.1 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.

Тус газарт үйлдэгдсэн гэмт хэргийн халдлагад **5748** иргэн (үүнээс: эмэгтэй 1635, 7 хүртэлх насны 22, 8-17 насны 458, 18-24 насны 1248, 25-29 насны 1132, 30-34 насны 857, 35-аас дээш насны 2031) өртөж, **8.9** тэрбум төгрөгийн хохирол учирснаас **3.3** тэрбум буюу **37.1** хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба гэмт хэргийн улмаас **74** хүн нас барж, **3063** хүн эрүүл мэндээрээ хохирчээ.

Нас барсан хүмүүсийг насаар нь ангилвал: 7 хүртэлх насны 2, 8-17 насны 6, 18-29 насны 16, 30-34 насны 10, 35-аас дээш насны 40 хүн байхаас гадна эдгээр хүмүүс нь хүнийг санаатай алах, бусдыг болгоомжгүй алах, зам тээврийн осол хэргийн улмаас амь насаа алдсан байна.

Гэмтсэн хүний хувьд: 7 хүртэлх насны 16, 8-17 насны 248, 18-24 насны 716, 25-29 насны 627, 30-34 насны 448, 35-аас дээш насны 1008 хүн байгаа бөгөөд өртсөн гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл хүчиндэх, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргүүд зонхилж байна.

Гурав. Нийслэлийн хэмжээний нөхцөл байдал: Нийслэлийн хэмжээнд 2014 онд **4252** гэмт хэрэг бүртгэгдэж (нийслэлд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 24.8 хувь) өмнөх оны мөн үеийнхээс 287 хэргээр буюу 7.2 хувиар өссөн статистик үзүүлэлттэй гарсан.

Сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 2501 гэмт хэрэг бүртгэгдэж, 1470 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдож, **илрүүлэлт 58.8** хувьтай байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар



Нийслэлийн хэмжээнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр хорооллын гудамжинд үйлдэгдсэн гэмт хэрэг 28 хэрэг (1.9%), тоглоомын талбайд 2 хэргээр (5.7%) буурсан, орон сууцны гудамжинд 127 хэрэг (10.1%), ил зогсоол дээр 59 хэрэг (15.1%), автобусны буудал дээр 68 хэрэг (22.3%), бусад газарт 62 хэрэг (12.2%) цэцэрлэгт хүрээлэнд 1 хэрэг (3.0%) тус бүр өссөн байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт харьцуулсан байдал



2014 онд нийслэлийн хэмжээнд гудамж талбайд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 17.6 хувь нь Баянгол, 28.2 нь Баянзүрх, 11.9 нь Сүхбаатар, 17.9 нь Сонгинохайрхан, 7.2 нь Хан-Уул, 14.7 нь Чингэлтэй, 1.3 нь Багануурт, 1.0 нь Налайх, 0.1 нь Багахангай дүүрэгт тус тус бүртгэгджээ. Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол зэрэг дүүрэгт гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг бусад дүүрэгтэй харьцуулахад их үйлдэгджээ.

2014 онд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэгт 3497 хүн холбогдон шалгагдсаны 11.9 хувь нь эмэгтэй, 2.6 хувь нь хүүхэд, 33.2 хувь нь 18-24 насны, 21.9 хувь нь 25-29, 37.7 хувь нь 30-аас дээш насны, 22.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 9.2 хувь нь хувийн хэвшилд ажилладаг, 50.3 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 10.0 хувь нь оюутан, сурагч, 1.2 хувь нь тэнэмэл, 2.6 хувь нь төрийн албан хаагч, 0.9 хувь нь ажилчин, малчин иргэд байна. Дээрхи хүмүүсийн 26.8 хувь нь согтуугаар, 21.9 хувь нь бүлэглэн үйлдсэн, 4.0 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс байжээ.

Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн халдлагад **4281** иргэн өртөж, **7.5** тэрбум төгрөгийн хохирол учирч, түүнээс 2.2 тэрбум буюу **29.3** хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба гэмт хэргийн улмаас 43 хүн нас барж, 2094 хүн эрүүл мэндээрээ хохирчээ.

Улсын хэмжээнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн ихэнхи (76 хувь нь) нь нийслэлд үйлдэгдсэний дотор гэр хорооллын гудамж, орон сууцны хорооллын гудамж талбай, ил зогсоол, автобусны буудал дээр бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах, хүчиндэх, булаах, дээрэмдэх гэмт хэргийн гаралт харьцангуй өндөр байна.

Бодлогогүй хот төлөвлөлт, иргэдийн шилжилт хөдөлгөөн зэрэг хүчин зүйлүүд гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна.

- *Гудамж талбайд* үйлдэгдсэн гэмт хэргийн **15.8 хувь** нь бүлэглэн гүйцэтгэсэн, **27.1 хувь** нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ олон нийтийн газарт биеэ зөв авч явахгүй байх хэсэг бүлгээрээ нийлж бусдыг зодож, бие махбодид нь гэмтэл учруулсан, танхайрсан, түүнчлэн бусдын эд зүйлийг булаах, дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

- *Гэр хорооллийн гудамжинд* үйлдэгдсэн гэмт хэргийн **19.0 хувь** нь хулгай *(иргэд халааснаасаа мөнгө, гар утас, эд зүйл алдах зэргээр),* **0.2 хувь** нь орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах гэмт хэрэг, **31.1 хувь** нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, **15.0 хувь** нь танхайрах, **12.8 хувь** нь дээрэмдэх, **0.5 хувь** нь хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нь хувь хүний ёс суртахууны доголдолтой байдал, согтууруулах ундаа хэрэглэсэн нөхцөл байдалтай холбоотойгоор бусдад зодуулах, бусдыг зодох, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохироох, бусдын амь насыг хохироох зэрэг байдалд хүргэж байна.

Ялангуяа гэр хорооллын иргэд гэрийн тэжээвэр нохойгоо уяагүй сул орхих, эзний хайхрамжгүй байдлаас болж иргэд эрүүл мэндээр хохирч байна. Дээрхи гэмт хэргийн 66.6 хувийг 14-22 цаг, 33.3 хувийг 06-14 цагт үйлдсэн байна.

- *Орон сууцны хорооллын гудамжинд* үйлдэгдсэн гэмт хэргийн **31.1. хувь** нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, **19.1 хувь** нь хулгайлах, **12.8 хувь** нь дээрэмдэх, **15.0 хувь** нь танхайрах, **0.5 хувь** нь хүнийг санаатай алах, **0.2 хувь** нь бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг байна. Гэмт хэргийн **488** буюу 29.6 хувийг согтуугаар, **299** буюу 18.2 хувийг бүлэглэн үйлджээ. Эдгээр гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь архидан согтуурсан, хувь хүний

хоорондын таарамжгүй харьцаа, үл ойлголцох байдал, иргэдийн өөрсдийн сонор сэрэмж, анхаарал болгоомжгүй байдлаас үүдэн гарч байна.

- *Ил зогсоол дээр* үйлдэгдсэн гэмт хэргийн **60.9 хувь** нь (*үүнээс хувийн өмч- 37.6 хувь, автомашины эд ангийн хулгай 62.4 хувь*) хулгайлах гэмт хэрэг голлон үйлдэгдэж байгаа нь иргэдийн өөрсдийн хяналт сул, машинаа зогсоол дээр орхиж явахдаа хаалга, цонхоо шалгадаггүй байдалтай холбон үзэж болно. Энэ нь орчны хяналтын камерын болон цагдаагийн эргүүл шалгалт шаардлагын хэмжээнд хүрдэггүй, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж байгаа ажиллагаа хүртээмж муутай байгаагаас шалтгаалан тухайн газарт хэрэг үйлдэгдэх нөхцөл бололцоо бүрдсэн байх талтай.

- *Автобусны буудалд дээр* үйлдэгдсэн хэргийн **37.2 хувь** нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, **15.7 хувь** нь танхайрах, **27.4 хувь** нь хулгайлах (үүнээс: халаасны хулгай 75.5 хувь) хэрэг байна.

Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх зарим асуудал

Гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь хотжилт, түүнийг дагасан шинэ суурьшилт, тэдгээрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах техник, технологийн төлөвлөлт, түүнд тавих хяналтаас гадна хууль сахиулах байгууллагын хуулиар хүлээлгэсэн үүргээ хэрэгжүүлэх стратеги, бодлого түүнчлэн иргэдийн эрх зүйн ухамсар, соёл зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай.

Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа нь ямар нэгэн өөрчлөлтгүй, хэвшмэл байдалд орсон, нэгэнт гарсан гэмт хэрэг, зөрчлийг шалгах, шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт болон механизм боловсронгуй бус, төрийн албан хаагчийн ажилдаа хандах хандлага, сэтгэлгээ, мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар зэрэг хүчин зүйлс нь гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэхэд хүндрэл учруулж байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Улсын хэмжээнд гудамж талбай, орон сууц, орчныг камержуулах хууль зүйн учир холбогдлыг таниулах ажлыг эрчимжүүлэн камержуулалт, дохиоллын системийн стандартыг зохих байгууллага тогтоож байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран үр нөлөөтэй ажиллах нөхцлийг бүрдүүлэх,
2. Гудамж, талбай, олон нийтийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэргийн цахим зураглалыг нэвтрүүлж, түүнтэй уялдуулан цагдаагийн хяналтыг судалгааны үндсэн дээр явуулах ажлыг зохион байгуулах,
3. Улс, нутаг дэвсгэр, байгууллагын тэмдэглэлт ой, баяр, ёслолын арга хэмжээ, амралттай холбогдуулан согтууруулах ундааны зохистой хэрэглээний учир холбогдлыг албан болон албан бус сургалт явуулах, цагдаагийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахдаа олон улсын жишиг, туршлагыг нэвтрүүлэх,
4. Хот суурин газарт орон гэргүй иргэд бусдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин гэмт хэрэг, зөрчилд холбогдох төдийгүй, золгүй байдлаар улирлын чанартайгаар амь нас, эрүүл мэндээрээ хохирох зэргээр нийгмийн сэтгэл зүйг түгшээсээр байгаад дүгнэлт хийж хүмүүнлэгийн төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн засаг захиргаа, төрийн байгууллагаас дэмжин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх,
5. Цагдаагийн албаны тухай хуулийн үзэл баримтлалын дагуу олон нийтийн цагдаагийн ажилтныг сонгон авах, тэдгээрийн ажиллах нийгэм, эдийн засгийн бололцоог нутаг дэвсгэрийн өөрөө удирдах болон засаг захиргаа, цагдаагийн байгууллагаас бүрдүүлэн, иргэнийг мэргэжлийн удирдлагаар ханган цагдаагийн алба, хаагчид бодитой дэмжлэг болохуйц байдлаар ажиллуулах асуудлыг бодлогын түвшинд судлан авч үзэж, шийдвэрлэх,

6. Харилцаа холбоо, мэдээллийн эринд үүрэн холбооны технологийн шинэчлэлтэй холбоотойгоор халаасны хулгай, тэдгээрийг дагасан ченж тодотголтой гэмт хэргийн замаар олсон зүйлийг борлуулах сүлжээ бий болж олон нийтийн дунд бухимдлыг төрүүлж цагдаагийн байгууллагад үл итгэх хандлагад нөлөөлж буй тул энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх нэгж, албын бүтцийг шинэчлэх, энэхүү гэмт явдалтай тэмцэх ажлын арга зүйд анхаарах.

--ooOoo --

ХОЁР. ДҮГНЭЛТ

Бүртгэгдсэн гэмт хэргийн хөдөлгөөн нь нутаг дэвсгэрийн хүн амын нягтралт, шилжилт, хөдөлгөөн, суурьшил болон гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай.

Түүнчлэн иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахаар цагдаагийн байгууллагад хандах сэтгэлгээ өөрчлөгдөж цагдаагийн ажил, үйлчилгээ иргэдэд ойртож байгаатай холбон тайлбарлаж болох боловч нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал улмаар хууль сахиулах байгууллагуудын ажиллах эрх зүйн орчин, үйл ажиллагаатай холбоотойгоор иргэд, гэмт халдлагын улмаас хохирч эрх, эрх чөлөө нь зөрчигдөх явдал буурахгүй байна.

Статистикт тусгагдсан гэмт хэрэг өссөн, буурсан үзүүлэлтүүдийг голчлох бус, тухайн орон нутагт хүний эрх, эрх чөлөөний баталгаа болох эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл, цагдаагийн ажил, үйлчилгээний түвшин, иргэдийн сэтгэл ханамж зэрэг олон хүчин зүйлийг үнэлж үзэх шаардлагатай байна.

Цаашид гэмт хэргийн гаралт, түүнийг бүртгэх механизмыг иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй болгож гарсан хэрэг нэг бүрийг бүртгэх, цагдаагийн байгууллагад итгэх иргэний итгэл, эрх ашгаа хамгаалуулах нийгмийн шаардлагыг нөхцөлдүүлэх нь чухал байна.

Нийслэлд орон нутгаас шилжин суурьшигчдын тоо жилээс жилд нэмэгдэн хот өргөжин тэлэхийн зэрэгцээ хотжилтын зарим сөрөг үр дагавар гэмт явдлын шалтгаан нөхцөл болж байгаа нь тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистикаар гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг дүгнэхэд бэрхшээлийг бий болгож буйг цаашид анхаарах нь зүйтэй байна.

Цаашид дээрх төрлийн гэмт хэргүүдтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн цагдаагийн алба хаагч объектийн судалгааг үр дүнтэй явуулан нийгмийн хөгжлийн явцад үйлдэгдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нэгэнт үйлдэгдсэн хэргийг илрүүлэхэд алба хаагчдын мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх албаны сургалтыг үр өгөөжтэй зохион байгуулах талаар ажлын чиглэл өгөх,
2. Аж ахуйн нэгж, байгууллагын камержуулалт, дохиоллын системийн стандартыг зохих байгууллага тогтоосноор цагдаагийн байгууллага нь хуулиар харъяалуулсан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нөхцлөөр хангагдан тухайн байгууллага, аж ахуйн нэгжтай хамтран ажиллах,
3. Гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд олон улсын жишиг, туршлагийг судлан криминалистикийн орчин үеийн дэвшилтэд арга, шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлэх талаар хариуцсан нэгж байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах, харъяа цагдаагийн газар, хэлтсийн криминологи судалгааны багийн үйл ажиллагааг дэмжиж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэсэн урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах, хөрөнгө, санхүүгийн туслалцаа дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;
4. Цагдаагийн албаны тухай хуульд баталгаажуулагдсан Мэдээлэл нэгтгэн боловсруулах үүрэг бүхий төвийг олон улсын цагдаагийн байгууллагын жишиг туршлагын дагуу судлан байгуулах, түүний хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн үе шаттайгаар нэвтрүүлэх,
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, ялангуяа хууль сахих эрх зүйн соёл ухамсарыг төлөвшүүлэх олон талт шинэлэг арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх,

6. Иргэдийн амар тайван амьдралын баталгааг бүрдүүлэх зорилгоор олон улсын жишиг туршлага болох гэмт хэрэг, зөрчлийн цахим зураглалыг нэвтрүүлэн түүнтэй уялдуулан цагдаагийн хяналтыг судалгааны үндсэн дээр явуулах ажлыг зохион байгуулах,
7. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх ялангуяа согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний зохистой харьцааг бий болгох, гэр бүлийн хүрээнд архидалттай тэмцэх зорилгоор төрийн болон мэргэшсэн төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авах, тухайлбал, Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийг байгуулан хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, зөвлөгөө өгөх байгууллага, мэргэжилтний үйл ажиллагааг идэвхижүүлэх, хохирогчдыг хамгаалах, эрүүл мэнд, сэтгэл засал, нийгмийн бусад үйлчилгээг хүргэх төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;
8. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундааны аюул, хувь хүний ёс суртахууны талаарх хэрэгцээтэй мэдээлэл, сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн оюутан, сурагчдад (эрүүл мэнд, хүүхдийн, уламжлалт шашны г.м) тогтмол явуулж хэвших;
9. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийгэмд сөрөг нөлөө үзүүлж буй мэдээлэлд (садар самууныг хэт ил гаргасан нэвтрүүлэг, зар сурталчилгаа, кино гэх мэт) тавих хяналтыг сайжруулан, хууль зөрчсөн мэдээлэлд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон Садар самуунтай тэмцэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллах;
10. Ерөнхий боловсролын сургууль бүрийг аюулгүй байдал, харуул хамгаалалт хариуцсан ажилтантай болгож, эдгээр ажилтнаас шаардлагатай мэдээллийн дэмжлэг авч ажлыг зохион байгуулах,
11. Зохион байгуулалттай, улс дамнасан гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон энэхүү гэмт хэргийг мөрдөн шалган байгууллагын бүтэц, тогтолцоог бий болгон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлалыг хангах зорилгоор ОХУ болон БНХАУ-ын мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, стратегийн баримт бичгүүдтэй уялдсан баримт бичгүүдийг боловсруулан баталж, олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох,
12. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист донтох нь хэрэглэгчийн хувьд өвчин тул донтой хүнд олон улсын жишиг, туршлагын дагуу олон талт эмчилгээ хийх бололцоо нөхцлийг бүрдүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллага үйл ажиллагаагаа чиглүүлэх,
13. Зүүн өмнөд Азийн улс орнуудын мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагатай харилцаа холбоо тогтоож, мэдээ, мэдээлэл солилцохоос гадна хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулан Монгол иргэд олноор зорчиж, сурч ажиллаж, амьдарч буй улсуудад гэмт хэрэгт хохирсон болон холбогдон шалгагдаж байгаа өөрийн орны иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, улс дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ижил төстэй байгууллагуудын хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн атташе томилон ажиллуулах;
14. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх олон нийтийн газруудыг байгуулах нь согтууруулах ундаагаар үйлчлэх газраас эдийн засгийн ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх тухайлбал, татварын хөнгөлөлтийн төрийн зохицуулалтыг хийх талаар холбогдох яам, агентлагт холбогдох саналыг хүргүүлэн хамтран ажиллах,
15. Улс, нутаг дэвсгэр, байгууллагын тэмдэглэлт ой, баяр, ёслолын арга хэмжээ, амралттай холбогдуулан согтууруулах ундааны зохистой хэрэглээний учир холбогдлыг албан болон албан бус сургалт явуулах, цагдаагийн хяналтыг үр дүнтэйтэй зохион байгуулахдаа зарим нутаг дэвсгэрийн жишиг, санаачлага туршлагыг нэвтрүүлэх, дэмжих

16. Хот суурин газарт орон гэргүй иргэд бусдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин гэмт хэрэг, зөрчилд холбогдох төдийгүй, золгүй байдлаар улирлын чанартайгаар амь нас, эрүүл мэндээрээ хохирох зэргээр нийгмийн сэтгэл зүйг түгшээсээр байгаад дүгнэлт хийж хүмүүнлэгийн төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн засаг захиргаа, төрийн байгууллагаас дэмжин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх,
17. Цагдаагийн албаны тухай хуулийн үзэл баримтлалын дагуу олон нийтийн цагдаагийн ажилтныг сонгон авах, тэдгээрийн ажиллах нийгэм, эдийн засгийн бололцоог нутаг дэвсгэрийн өөрөө удирдах болон засаг захиргаа, цагдаагийн байгууллагаас бүрдүүлэн, иргэнийг мэргэжлийн удирдлагаар ханган цагдаагийн алба, хаагчид бодитой дэмжлэг болохуйц байдлаар ажиллуулах асуудлыг бодлогын түвшинд судлан авч үзэж, шийдвэрлэх,
18. Харилцаа холбоо, мэдээллийн эринд үүрэн холбооны технологийн шинэчлэлтэй холбоотойгоор халаасны хулгай, тэдгээрийг дагасан ченж тодотголтой гэмт хэргийн замаар олсон зүйлийг борлуулах сүлжээ хэдийнээ бий болж олон нийтийн дунд бухимдлыг төрүүлж цагдаагийн байгууллагад үл итгэх хандлагад нөлөөлж буй тул энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх нэгж, албын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, энэхүү гэмт явдалтай тэмцэх ажлын арга зүйд анхаарах.

--ooOoo--

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлнээ:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль, 1993 он
- Цагдаагийн албаны тухай хууль, 2013 он
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, 2000 он
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2004 он
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, 2013 он
- Үндэсний статистикийн хороо, Статистикийн бюллетень, 2012 он
- Статистик мэдээ, ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв, 2003-2013
- 2003-2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт, УБ, 2013 он
- Нийгмийн хэв журам хамгаалах газрын статистик мэдээ, танилцуулга, 2003-2013
- Эрүүгийн цагдаагийн газрын танилцуулга, 2012-2013
- Нийслэлийн өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл бодисын хэрэглээ, ойлголтын талаархи тандалт судалгаа”-ны тайлан, 2012 он
- “Цаг үе, дэнс” 14 хоног тутмын сэтгүүл, 2013
- Гэмт явдалтай тэмцэх асуудал, улирал тутмын сэтгүүл, 2004-2013 он
- “2003-2008 онд Монгол Улсад амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлын тархалт” судалгааны ажлын тайлан, ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС, СЭМТ 2013 он
- Гэр бүл, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн өнөөгийн байдал, бууруулах арга зам сэдэвт салбар дундын зөвлөлдөх уулзалтын тайлан, Улаанбаатар хот, 2008 он
- “Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал” товхимол, 2010, 2011, 2012 он /цуврал/
- www.criminology .mn

Гадаад хэлнээ:

- GIS Tutorial for Crime analysis, Gorr and Kurland, 2012
- Criminal Justice, James A Inciardi, 2005
- Black’s law dictionary, Abridged fifth Edition,1987
- Theoritical criminology, S.T.Reid, 2012
- Crime and undercover working, Police chief association, 2012
- Oxford dictionary of law, Third edition, 1994
- Fusion center /Wikepedia 2013/
- Golden shield implemention by China, 2013
- Information-led Policing, Professor Lu Shaozhong, 2013